



МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.05.16 № 3Г-1/61
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Д.ОЮУН-ЭРДЭНЭ

000754000288



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.05.05 № НХ/1261
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.



Хавсралт 109 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

. 000255000484



**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй." гэж, мөн хуулийн Арван долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн." гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.3-т "хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх зорилт"-ын хүрээнд 2021-2030 онд "Цахим хэлбэрт шилжсэнээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ шат дамжлагагүй, шуурхай болно" гэж, мөн зорилт 6.2-т "байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилт"-ын хүрээнд 2021-2030 онд "Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах" гэж тус тус заасан бөгөөд салбарын төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй хүргэх замаар байгаль орчныг хамгаалах тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 30-д "Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбогдсон зохицуулалтыг боловсронгуй болгох" үндэслэлээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилтыг дэвшүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Ногоон хөгжлийн сэргэлтийн 5.4-т “Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно” гэж, Төрийн бүтээмжийн сэргэлтийн 6.1-д “Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна” гэж, мөн тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.д-т “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байгаль орчны хяналт, шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгон хэрэгжүүлэх” гэж тус тус заасан байна.

1.2. Практик үндэслэл, шаардлага

2009-2012 онд хэрэгжүүлсэн эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд байгаль орчны салбарын 33 хуулиас 18 хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах судалгааг хийж, судалгааны үр дүнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталсан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш 11 жилийн хугацаанд хуулийн зарим зүйл, заалт хоорондоо зөрчилдөх, зохицуулалтын хувьд давхцах, тодорхой бус, хоёрдмол утга илэрхийлэх, төсөл хэрэгжүүлэгчид эдийн засгийн болоод цаг хугацааны хүндрэл учруулах зэрэг бэрхшээл гарч байгааг асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас 2022 онд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж тогтоосон байна. Тухайлбал:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4.8-д байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн Нийтийн хурлын санал, тэмдэглэлийг тусгахаар заасан нь хоёр нэгжээс санал, тэмдэглэл авах хоёрдмол утгыг илэрхийлж байгааг тодорхой болгох шаардлагатай бөгөөд уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд олон талын хүндрэл тулгарч байна. Багийн иргэдийн Нийтийн Хурал нь жилдээ 1-2 удаа хуралдах тохиолдол их байх тул төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага иргэдийн Нийтийн Хурал хуралдахыг хүлээж цаг хугацаа, эдийн засгийн хувьд алдагдалд орж хөрөнгө оруулалтаа алдах зэрэг бэрхшээл гарч байна. Тухайлбал, авто болон төмөр зам, нефть, цацраг идэвхит ашигт малтмалын хайгуулын төсөл зэрэг олон аймаг, сум, багийн нутаг дэвсгэрийг хамарч хэрэгждэг төслийн хувьд төслийн нөлөөлөлд өртөх баг бүрээс санал авах боломжгүй байна.

2. Тухайн төслийн хүчин чадал, хамрах хүрээ, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл зэргийг үл харгалзан бүх төрлийн нарийвчилсан үнэлгээний тайланг Үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр зохицуулсан нь эдийн засгийн болоод цаг хугацааны хувьд төсөл хэрэгжүүлэгч нарт

хүндрэл учруулж байна. Иймд төслийн хүчин чадал, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл зэргийг харгалзан үзэж, тодорхой төрлийн төслийн нарийвчилсан үнэлгээний тайланг үнэлгээний шинжээч шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэж байх зохицуулалтыг хуульчлах хэрэгтэй байна.

3.Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, стратегийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 2012 онд батлагдсанаас хойш стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ ердөө 4 удаа хийгдсэн байна. Цаашид энэхүү үнэлгээг хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт тусгах шаардлагатай байна.

4.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний төслийн ангиллыг хуулийн хавсралтаар хатуу тогтоосныг төсөл, хөтөлбөр, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, салбарын онцлог, олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэхээс гадна тухайн төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан тогтоох шаардлага тулгарч байна.

5.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, иргэд тухайн төслийн үйл ажиллагаатай холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах шаардлага гардаг бөгөөд мэдээллийг авч чаддаггүй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, төрийн албан тушаалтнаас мэдээлэл гаргаж өгөх, олон нийтэд нээлттэй байлгах асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжтой уялдуулан нийцүүлэх шаардлагатай байна.

6.Олон улсын жишигт нийцүүлэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд байгаль орчны нийгмийн нөлөөллийн үнэлгээг тусгах, хамрах хүрээг тодорхой болгох, уурхайн хаалтын төлөвлөгөөг Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, хугацааг илүү тодорхой болгох, олон улсын банк, санхүүгийн байгууллагын стандартаас шалтгаалан нөлөөллийн үнэлгээний тайланг хүлээн авахад гардаг хүндрэлүүдийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тусгах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

7.Байгаль орчны үнэлгээний цахим системийг төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрт нийцүүлэн нэвтрүүлэх замаар үнэлгээний оролцогч талуудын үйл ажиллагааг хөнгөвчлөх, дэмжлэг үзүүлэх, цаг хугацаа хэмнэх шаардлага тулгарч байна.

8.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой хүсэлтийг нутгийн өөрөө удирдах байгууллага хүлээн авч, иргэний мэдэх эрхийг хангах үүргийг биелүүлж байх эрх зүйн зохицуулалтыг хийх зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглах үйл ажиллагааг зохицуулах үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын шаардлагад нийцүүлж, үнэлгээ хийх үе шатанд төрийн оролцоог бууруулах, төвлөрлийг сааруулах, холбогдох хууль тогтоомж, хөгжлийн бодлоготой уялдуулах зорилгоор хуулийн төсөлд дээр дурдсан практик шаардлагад үндэслэн дараах асуудлыг тусгана. Үүнд:

-Байгаль орчны стратегийн үнэлгээг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүрэг болгон хэрэгжүүлэх өөрчлөлт;

-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах замаар иргэний мэдэх эрхийг хангах төрийн үүргийг тусгах;

-Байгаль орчны үнэлгээний цахим шилжилт болон мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлэн бүрдүүлэх зохицуулалт;

-Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахад сум, дүүргийн Засаг даргын санал өгөх хугацаа, шаардах бичиг баримтын төрлийг тодорхой тусгах;

-Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тухайн төслийн хүчин чадал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн цар хүрээнээс хамааран ялгамжтай хугацаа, хуулиар тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг харгалзан батлах зохицуулалт;

-Байгаль орчны үнэлгээний шинжээчид тавих шаардлага, шалгуур, үүрэг, хариуцлагыг тодорхой болгож тусгах;

-Тухайн төслийн ангиллыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар бус, уг хуулийн хүрээнд Засгийн газрын тогтоолоор баталж, хэрэгжүүлэх, тодорхой төрлийн төслийн нарийвчилсан үнэлгээний тайланг батлагдсан ангиллын дагуу үнэлгээний шинжээч шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэж байх өөрчлөлт;

-Хуримтлагдах нөлөөллийг мэргэжлийн байгууллагаас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүний нэмэлт тодотгол болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж үр дүнг тооцож байх зохицуулалт;

-Мөн хуульд заасан зарим бичиг баримтын бүрдлийн ангилал ойлгомжгүй, давхцсан байдлыг арилгаж, үүрэг хариуцлагын зохицуулалтыг тодорхой тусгана.

-Төрийн зарим байгууллага төсөл хэрэгжүүлэгч бүрээс байгаль орчны нөлөөллийн үнэлгээ шаарддаг асуудлыг хязгаарлах зохицуулалтыг тус тус тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авах арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээл арилж, нийгэм, эдийн засаг, хууль зүйн ямарваа нэгэн сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд дараах эерэг үр дагавар гарна гэж үзэж байна. Үүнд:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт сайжирч, төсөл хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулагч нарт учирч байсан цаг хугацаа алдах, бичиг баримтын бүрдэл хангах, хүлээх, төрийн байгууллага хооронд явах асуудал цэгцэрч, олон улсын жишгийг даган зөвхөн танилцуулга, нөлөөлөлд өртсөн иргэдэд танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан тайланг нарийвчилсан үнэлгээнд тусгадаг болсноор иргэдийн Нийтийн Хурал хуралдахгүй удах, түүний улмаас төслийн хугацаа хойшлох, санхүүгийн алдагдал хүлээх зэрэг асуудлыг цогцоор нь шийдэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд учирч байсан Засаг даргын санал авах, төсөл хэрэгжих багаас зөвшөөрөл авах хэлбэрээр хурал зохион байгуулахаар олон дахин явж хугацаа алдах зэрэг асуудал нэг мөр шийдвэрлэгдэнэ.

Асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгаль орчны үнэлгээтэй холбоотой төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй хүргэх, цахим хэлбэрээр ажиллах, мэргэшсэн мэргэжилтэн нарыг ажиллуулах, төвлөрлийг сааруулах, оролцогч талуудын ажлын уялдаа холбоо сайжрах нөхцөл бүрдэнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэдийн мэдэх эрхийг байгаль орчны үнэлгээ хийх шатанд хангах замаар ил тод мэдээллээр хангагдах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг

хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

--- оОо ---

**“БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ТӨСЛИЙН
ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА**

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх зүйн орчныг шинэчлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлээр “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд чиглэл болгож, мөн Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 233 дугаар тогтоолоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхийг шаарддаг үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай, барилга байгууламжийн төрлийг оновчтой болгож тоог цөөрүүлэх, үнэлгээ хийх бүх үе шатанд төрийн оролцоог хамгийн бага түвшинд байхаар бууруулах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, бизнес дэх байгаль орчны үнэлгээний ангиллыг цөөрүүлж, төрийн оролцоог бууруулах” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулсан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын (хуучин нэрээр) 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар байгуулж, хуулийн төслийн нэмэлт өөрчлөлт, техникийн болон найруулгын боловсруулалтыг сайжруулан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2024 оны 01/2721 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан шинэ Засгийн газрын гишүүдээс санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр дахин ирүүлэх нь зүйтэй гэсэн чиглэлийг өгч буцаасан.

Дээрх чиглэлийн дагуу “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулж, батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7, 20.8-д заасны дагуу Сангийн сайдын 2025 оны 01/551, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 1/705 дугаартай албан бичгүүдээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийн дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.

Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна:

1.Хуулийн төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны (хуучин нэрээр) цахим сайт болох <https://met.gov.mn/> вэб сайтад 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 30 хоногийн хугацаанд байршуулан олон нийтийн саналыг авсан байна.

Хуулийн төсөлд 1 иргэн, 4 аж ахуйн нэгжээс 11 заалтад санал ирүүлснийг хянан үзээд 2 саналыг хуулийн төсөлд тусган, хуулийн төслийн үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийцээгүй 9 саналыг тусгаагүй болно.

2.Хуулийн төслийг Байгаль орчны үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагууд, Нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Ашигт малтмал газрын тосны газар, Ойн газар, Усны газар, Цаг уур орчны шинжилгээний газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад, Олон улсын байгууллагууд, “Монголын Байгаль орчны иргэний зөвлөл” төрийн бус байгууллагуудын холбоо, төсөл хэрэгжүүлэгч томоохон аж ахуйн нэгжүүд болон холбогдох бусад байгууллагын төлөөллийг оролцуулсан 3 удаагийн томоохон хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн тусгасан.

3.Хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналыг хянан үзэхэд эхний санал авалтад 4 сайд дэмжиж, 6 сайд санал ирүүлээгүй бөгөөд 3 сайдын саналыг тусгаж, 7 сайдын санал нь утга агуулга давхардсан, хөндөөгүй заалтад санал өгсөн, тусгах шаардлагагүй санал ирүүлсэн зэргийг хянан үзээд холбогдох тайлбар, үндэслэлийг гаргасан. Шинэчлэгдэн батлагдсан үзэл баримтлалын хүрээнд Засгийн газрын 22 гишүүнээс 12 гишүүн саналгүй, 3 гишүүн хуулийн хугацаанд санал ирүүлээгүй, 7 гишүүн нийт 35 санал ирүүлснээс 8 саналыг хуулийн төсөлд тусгаж, 17 саналыг тусгаагүй бөгөөд холбогдох санал тус бүрт тайлбар, үндэслэлийг гаргасан.

Байгаль орчны салбарт 2009-2012 онд хийгдсэн эрх зүйн өөрчлөлтийн хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. Хууль хэрэгжсэн 13 жилийн хугацаанд хуулийн зарим зүйл, заалт хоорондоо зөрчилдөх, зохицуулалтын хувьд давхцах, тодорхой бус, хоёрдмол утга илэрхийлэх, төсөл хэрэгжүүлэгчдэд эдийн засгийн болоод цаг хугацааны хүндрэл учруулах зэрэг бэрхшээл гарсан.

Иймээс байгаль орчин, уур амьсгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох судалгааг хийж эдийн засаг, хөгжлийн хувьд харилцан адилгүй боловч байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийж байгаа эрх зүйн орчин ижил түвшний 5 улс (Англи, Канад, Өмнөд Африк, Хятад, Казакстан), байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг үйл ажиллагаандаа ашигладаг 5 олон улсын байгууллага (Дэлхийн Банк, Азийн хөгжлийн Банк, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпорац)-ын туршлагыг судалж харьцуулсан шинжилгээ хийж, Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ”-г хийж дараах нөхцлийг тогтоосон байна:

-Нарийвчилсан үнэлгээний тайланд "...төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын санал, тэмдэглэл..." байна гэж заасныг хэрэгжүүлэхэд олон талын хүндрэл гарч хугацаа алдсанаас үүдэн шаардлагатай төслүүд гацдаг;

-Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний төслийн ангиллыг хуулиар хатуу тогтоосноор тухайн төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан үзэх боломжгүй болсон;

-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, тухайн төслийн үйл ажиллагаатай холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг энгийн иргэд хүлээн авах, танилцах боломжгүй;

-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээ, уур амьсгалын өөрчлөлт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын стандартыг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тусгах зэрэг хэрэгцээ шаардлага тулгарч байна гэж үзсэн.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр гарсан нөхцөл байдлыг хянан үзээд шаардлага нь тодорхойгүй, бичиг баримтын бүрдлийн ангилал ойлгомжгүй, давхцсан шинжтэй, үүрэг хариуцлагын зохицуулалт тусгагдаагүйн улмаас хууль хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлийг арилгах үүднээс зарим хэсэг, заалтыг шинээр нэмэх, зарим хэсэг, заалтыг өөрчлөн найруулах зэргээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн эх бичвэрт 19 хэсэг, 6 заалтыг нэмж тусган, 12 хэсэг, 3 заалтыг өөрчлөн найруулж, нийт хуулийн 48 заалт буюу 38.4%-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийг хэлэлцэн баталснаар:

1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт сайжирч, цаг хугацаа алдах, бичиг баримтын бүрдэл хангах, хүлээх, төрийн байгууллага хооронд явах, олон нийтийн оролцооны асуудлаас болж төслийн хэрэгжилт гацах, санхүүгийн алдагдал хүлээх зэрэг асуудлыг цогцоор нь шийдэх эрх зүйн орчин бүрдэнэ.

2.Асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгаль орчны үнэлгээтэй холбоотой төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй хүргэх, цахим хэлбэрээр ажиллах, мэргэшсэн мэргэжилтэн ажиллуулах, ангиллыг сайжруулах замаар төвлөрлийг сааруулах, оролцогч талуудын ажлын уялдаа холбоо сайжрах нөхцөл бүрдэнэ.

3.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинэчилсэн ангиллаар нийт төслийн **36%** нь ангилал буурч, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт хийлгэх болон шалгах хуудсаар бүртгүүлэх боломжтой болно.

Мөн аймаг, нийслэлийн түвшинд хийгдэж байгаа нөхцөл, болзолтой хийсэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийн **30%** нь шалгах хуудсаар бүртгүүлж, үнэлгээ шаардахгүй болно.

4.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний цахим шилжилт, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлж, байгаль орчны үнэлгээний харилцаанд иргэдийн мэдэх эрхийг хангах замаар мэдээллийн ил, тод байдлыг сайжруулах боломж бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

“БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх зүйн орчныг шинэчлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлээр “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд чиглэл болгож, мөн Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 233 дугаар тогтоолоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхийг шаарддаг үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай, барилга байгууламжийн төрлийг оновчтой болгож тоог цөөрүүлэх, үнэлгээ хийх бүх үе шатанд төрийн оролцоог хамгийн бага түвшинд байхаар бууруулах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, бизнес дэх байгаль орчны үнэлгээний ангиллыг цөөрүүлж, төрийн оролцоог бууруулах” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулсан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын (хуучин нэрээр) 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар байгуулж, хуулийн төслийн нэмэлт өөрчлөлт, техникийн болон найруулгын алдааг засаж боловсруулалтыг сайжруулан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2024 оны 01/2721 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан шинэ Засгийн газрын гишүүдээс санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр дахин ирүүлэх нь зүйтэй гэсэн чиглэлийг өгч буцаасан.

Дээрх чиглэлийн дагуу “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулж, батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7, 20.8-д заасны дагуу Сангийн сайдын 2025 оны 01/551, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 1/705 дугаартай албан бичгүүдээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийн дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.

Батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг боловсруулж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна:

1.Хуулийн төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны (хуучин нэрээр) цахим сайт болох <https://met.gov.mn/> вэб сайтад 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 30 хоногийн хугацаанд байршуулан олон нийтийн саналыг авсан байна.

Хуулийн төсөлд 1 иргэн, 4 аж ахуйн нэгжээс 11 заалтад санал ирүүлснийг хянан үзээд 2 саналыг хуулийн төсөлд тусган, хуулийн төслийн үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийцээгүй 9 саналыг тусгаагүй болно.

2.Хуулийн төслийг Байгаль орчны үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагууд, Нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Ашигт малтмал газрын тосны газар, Ойн газар, Усны газар, Цаг уур орчны шинжилгээний газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад, Олон улсын байгууллагууд, “Монголын Байгаль орчны иргэний зөвлөл” төрийн бус байгууллагуудын холбоо, төсөл хэрэгжүүлэгч томоохон аж ахуйн нэгжүүд болон холбогдох бусад байгууллагын төлөөллийг оролцуулсан 3 удаагийн томоохон хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн тусгасан.

3.Хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналыг хянан үзэхэд эхний санал авалтад 4 сайд дэмжиж, 6 сайд санал ирүүлээгүй бөгөөд 3 сайдын саналыг тусгаж, 7 сайдын санал нь утга агуулга давхардсан, хөндөөгүй заалтад санал өгсөн, тусгах шаардлагагүй санал ирүүлсэн зэргийг хянан үзээд холбогдох тайлбар, үндэслэлийг гаргасан. Шинэчлэгдэн батлагдсан үзэл баримтлалын хүрээнд Засгийн газрын 22 гишүүнээс 12 гишүүн саналгүй, 3 гишүүн хуулийн хугацаанд санал ирүүлээгүй, 7 гишүүн нийт 35 санал ирүүлснээс 8 саналыг хуулийн төсөлд тусгаж, 17 саналыг тусгаагүй бөгөөд холбогдох санал тус бүрт тайлбар, үндэслэлийг гаргасан.

Байгаль орчны салбарт 2009-2012 онд хийгдсэн эрх зүйн өөрчлөлтийн хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. Хууль хэрэгжсэн 13 жилийн хугацаанд хуулийн зарим зүйл, заалт хоорондоо зөрчилдөх, зохицуулалтын хувьд давхцах, тодорхой бус, хоёрдмол утга илэрхийлэх, төсөл хэрэгжүүлэгчдэд эдийн засгийн болоод цаг хугацааны хүндрэл учруулах зэрэг бэрхшээл гарсан.

Иймээс байгаль орчин, уур амьсгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох судалгааг хийж эдийн засаг, хөгжлийн хувьд харилцан адилгүй боловч байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийж байгаа эрх зүйн орчин ижил түвшний 5 улс (Англи, Канад, Өмнөд Африк, Хятад, Казакстан), байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг үйл ажиллагаандаа ашигладаг 5 олон улсын байгууллага (Дэлхийн Банк, Азийн хөгжлийн Банк, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпорац)-ын туршлагыг судалж харьцуулсан шинжилгээ хийж, Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ”-г хийж дараах нөхцлийг тогтоосон байна:

-Нарийвчилсан үнэлгээний тайланд “...төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын санал, тэмдэглэл...” байна гэж заасныг хэрэгжүүлэхэд олон талын хүндрэл гарч хугацаа алдсанаас үүдэн шаардлагатай төслүүд гацдаг;

-Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний төслийн ангиллыг хуулиар хатуу тогтоосноор тухайн төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан үзэх боломжгүй болсон;

-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах, тухайн төслийн үйл ажиллагаатай холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг энгийн иргэд хүлээн авах, танилцах боломжгүй;

-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээ, уур амьсгалын өөрчлөлт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын стандартыг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тусгах зэрэг хэрэгцээ шаардлага тулгарч байна гэж үзсэн.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр гарсан нөхцөл байдлыг хянан үзээд шаардлага нь тодорхойгүй, бичиг баримтын бүрдлийн ангилал ойлгомжгүй, давхцсан шинжтэй, үүрэг хариуцлагын зохицуулалт тусгагдаагүйн улмаас хууль хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлийг арилгах үүднээс зарим хэсэг, заалтыг шинээр нэмэх, зарим хэсэг, заалтыг өөрчлөн найруулах зэргээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн эх бичвэрт 19 хэсэг, 6 заалтыг нэмж тусган, 12 хэсэг, 3 заалтыг өөрчлөн найруулж, нийт хуулийн 48 заалт буюу 38.4%-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь аливаа төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө тухайн төсөл хэрэгжих явцад байгаль орчинд үүсэх сөрөг нөлөөллийг тогтоох, бууруулах арга хэмжээг зохицуулдаг бөгөөд бусад хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд:

Нэг.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг батлуулах үйл ажиллагааны хугацааг багасгах хүрээнд:

1.1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4.8-д нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн Иргэдийн Нийтийн Хурлын санал, тэмдэглэл гэж заасныг хэрэгжүүлэхэд олон талын хүндрэл тулгарч байна. Багийн Иргэдийн Нийтийн Хурал нь жилдээ 1-2 удаа хуралддаг, энэ хугацаанд төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага хурал хүлээж цаг хугацаа, эдийн засгийн хувьд алдагдалд орж хөрөнгө оруулалтаа алдах зэрэг бэрхшээл гардаг.

Хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн 10.5-д “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна” гэснийг “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулна.” гэж өөрчилсөн.

Энэ заалттай уялдуулан төслийн 8.4.8-ийг “энэ хуулийн 10.5-д заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд хийсэн танилцуулгын тайлан” гэж оруулснаар төсөл хэрэгжүүлэгч заавал багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоол гаргуулах шаардлагагүй болно. Мөн хуулийн 18.4.-д “Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.” гэснийг “Тухайн төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулах, санал авах шаардлагатай байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийг энэ хуулийн 7.7-д заасан үнэлгээ хийх төслийн ангиллаар батална.” гэж өөрчилсөн.

1.2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтэд Засаг даргын санал авахад тодорхой хугацаа шаарддаггүй ч, төсөл хэрэгжүүлэгчээс саналд ач холбогдолгүй янз бүрийн нэмэлт материал шаарддаг зэрэг асуудал гардаг. Үүнийг төслийн 7.3 дахь заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник, эдийн засгийн үндэслэл, эскиз зураг, бизнес төлөвлөгөө, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, эсхүл төлөв байдлын тодорхойлолт, тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал, холбогдох бусад бичиг баримтыг бүрдүүлэн энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ” гэсэн өөрчлөлт оруулж, 7.12-7.15 дахь заалтыг шинээр нэмж сум, дүүргийн Засаг даргын санал өгөх хугацаа, шаардах бичиг баримтыг тодорхой зааж оруулсан.

1.3.Төслийн хүчин чадал, хамрах хүрээ, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл зэргийг үл харгалзах бүх төрлийн нарийвчилсан үнэлгээний тайланг Үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр заасныг 8.9, 8.10, 8.11 дахь заалтуудаар илүү тодорхой, хугацаатай болгож нэмж тусгасан.

Дээрх өөрчлөлтийг оруулснаар ерөнхий үнэлгээний түвшинд Засаг даргын санал өгөх хугацаа, олон төрлийн бичиг баримт шаардаж цаг авдаг асуудал, нарийвчилсан үнэлгээний түвшинд жилдээ 1-2 удаа хуралдах багийн Иргэдийн Нийтийн Хурлын хугацаа, хуралд оролцогчдоос дэмжихгүй байгаа талаар гаргасан тогтоол зэргээс шалтгаалан төсөл хэрэгжиж чадахгүй байх асуудлыг шийдвэрлэж, одоогийн нөхцөл байдлаар хамгийн доод тал нь 120 хоногт батлагдаж байгаа үнэлгээг 43 хоногт баталж, хугацааг 3 дахин бууруулахаар тооцсон.

Хоёр.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхийг шаарддаг үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай, барилга байгууламжийн төрлийг оновчтой болгон тоог цөөрүүлэх хүрээнд:

2.1.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний төслийн ангиллыг хуулиар хатуу тогтоосныг зохицуулж төслийн ангиллыг Засгийн газраас баталдаг болгож уян хатан болгосон ба төслийн 7.7-д “Нөлөөллийн үнэлгээний журам, үнэлгээ хийх төслийн ангиллыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, ангилалд байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадлагаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьяалал, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн

болон эрүүл мэндийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана.” гэж өөрчлөлт оруулж 7.8, 7.9, 7.10, 7.11 дэх заалтуудыг тус тус шинээр нэмсэн.

Ингэснээр одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хавсралтад дурдсан бүх төсөлд ижил материал шаарддаг, бусад гэсэн ангилал, чиглэл оруулснаар хуулийн хийдэл үүсэх, шаардлагагүй төсөлд үнэлгээ хийх нөхцөл бүрдсэнийг болиулж, хуучин ангилалд байсан бусад төсөл гэснийг хүчингүй болгож, ангилал чиглэлийг тодорхой болгон хүрээг тогтоосон.

Тухайлбал, тухайн төслийн цар хүрээ, том жижгээс хамаарахгүй зөвхөн химийн бодис ашигладаг л бол байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэхээр хуульчилсныг бууруулж ангилалыг шинэчилсэн.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санд бүртгэгдсэн төслүүдэд дээрх аргаар шинжилгээ хийхэд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай төслүүдийн 26.1 хувь, нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагагүй төслүүдийн 10.2 хувь нь зөвхөн шалгах хуудсаар бүртгүүлэх боломжтой болж, нөхцөл болзолтой хийх ерөнхий үнэлгээний дүгнэлтийн 31.6 хувь нь үнэлгээ хийлгэх шаардлагагүй болж буурна.

2.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тухайн төслийн хүчин чадал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн цар хүрээнээс хамааран ялгамжтай хугацаа, шаардлагаар батлах зорилгоор хуулийн 9.2-д “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.” гэснийг “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэ хуулийн 7.9-д заасан ангиллаас хамааран 10 хүртэлх жилийн хугацаагаар батлах бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж өөрчлөн найруулсан.

Үүгээр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг зэрэглэл I төслүүдэд 5 жил тутамд, зэрэглэл II төслүүдийн зөвхөн шаардлагатай төсөлд 10 хүртэл жил тутамд, зэрэглэл III төсөлд хийх шаардлагагүй байхаар тусгаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батлуулах төсөл 50 хувиар буурах боломжийг бий болгож байна.

Гурав. Байгаль орчны үнэлгээний цахим шилжилт болон мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлэх хүрээнд:

3.1.Хуулийн 8.7-д “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь хээрийн судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 4 хувь бэлтгэж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсөл хэрэгжүүлэгч болон төсөл хэрэгжих сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт тус бүр 1 хувийг өгч, 1 хувийг өөртөө үлдээх бөгөөд тэдгээр нь адил хүчинтэй байна.” гэснийг “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчны мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална” гэж өөрчилсөн. Ингэснээр цаг хугацаа, материалын зардалд хэмнэлт гарч, төсөл хэрэгжүүлэгч заавал биеэр ирэх шаардлагагүй болно.

3.2.Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах асуудлыг хуульчлах, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдэх эрхийг хангах хүрээнд хуулийн төсөлд 14.1.5, 18.6, 18.7, 18.8 дахь заалтуудыг шинээр нэмж тухайн төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх явц, байгаль орчныг менежментийн төлөвлөгөөний биелэлтийг төслийн нөлөөлөлд өртөгч иргэн болон төслийн төлөөлөлд өртөгч талууд мэдэх эрхийг хуульчилсан.

Дөрөв.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн нэр томьёоны тайлбар хэсэг болон хуулийн зүйл, заалтын ижил бус утгыг тодорхой болгох хүрээнд:

4.1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.8-д заасан “Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд заасан агуулга ижил нэр томьёог дагаж өөрчлөх шаардлагатай тохиолдолд ижил утгаар ойлгож хэрэгжүүлэх, хэрэглэх тайлбарыг хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалтад тусгаж болно” гэсэн заалтын дагуу олон улсын хөтөлбөр, банк санхүүгийн байгууллагаас шаарддаг нийгмийн нөлөөллийн үнэлгээний асуудлыг хуулийн төслийн 3.1.6-д “байгаль орчны нөлөөллийн үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад төслийн нөлөөлөлд өртөх бүсийн байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй нөлөөлөл, цар хүрээ, үр дагаврыг төслийн үе шатуудад урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг тогтоохыг;” хэлнэ гэж өөрчлөн найруулснаар бусад 43 хуульд “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэсэн нэр томьёог хөндөх шаардлагагүйгээр зохицуулалтыг хийсэн.

Үүнийг дагуулан хуулийн 7.7-д нийгмийн нөлөөллийн аргачлалыг тусгаж, 17.2-д олон улсын банк санхүүгийн байгууллагаас шаарддаг байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг Монгол Улсын Байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй дүйцүүлэн хүлээн авахаар шинээр тусгасан.

4.2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх асуудлыг тодорхой болгож хуулийн “3.1.12-д “байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт” гэж энэ хуулийн 7.9.3-д заасан зэрэглэл III хамаарах төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнөх төслийн байршлын байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг”, 3.1.13-д “байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол” гэж төслийн хүчин чадал, технологи, байршил, талбайн хэмжээ өөрчлөгдсөн, хуулиар тогтоосон хугацаа дуусгавар болсон тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчлэн батлуулахыг” хэлнэ гэж нэр томьёоны тайлбарт тусгаж 6.7, 7.10, 7.11 дэх хэсэгт тодорхой заалтуудыг оруулсан.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн байгалийн нөөц баялаг төрийн хамгаалалтад байх тухай 6 дугаар зүйл, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг төрөөс хариуцан хангах тухай Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтуудтай бүрэн нийцэж байгаа бөгөөд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байгаль орчныг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, багц хуулийн хэрэгжилтийг хангах, байгалийн нөөц ашиглан үйл ажиллагаа явуулж буй төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг зорилтуудыг уг хуулийн төслөөр хангах боломжтой юм. Эрх зүйн зохицуулалтыг хийснээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилт сайжирч, төвлөрөл саарах, байгалийн нөөцийг ашиглагч нь хамгаалагч байх зарчмыг хэрэгжүүлэх нөхцөл бий болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.12, 3.1.13 дахь заалт:

“3.1.12.”байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт” гэж энэ хуулийн 7.9.3-т заасан зэрэглэлд хамаарах төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнөх төслийн байршлын байгалийн нөхцөл, орчны онцлогийг тогтоохыг;

3.1.13.”байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол” гэж төслийн хүчин чадал, технологи, байршил, талбайн хэмжээ өөрчлөгдсөн, хуулиар тогтоосон хугацаа дуусгавар болсон тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчлэхийг;”

2/4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг:

“4.4.Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3/6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэг:

“6.7.Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолтыг төсөл хэрэгжүүлэгч хариуцан гүйцэтгэх бөгөөд үнэлгээг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.14-т заасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санд бүртгүүлнэ.

6.8.Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хянах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

6.9.Тодорхой бүс нутаг, сав газарт хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.”

4/7 дугаар зүйлийн 7.8, 7.9, 7.10, 7.11, 7.12, 7.13, 7.14, 7.15 дахь хэсэг:

“7.8.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.9.Төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, төсөл хэрэгжих газар нутгийн байршил, хүчин чадлыг харгалзан дараах байдлаар ангилна:

- 7.9.1.зэрэглэл I;
- 7.9.2.зэрэглэл II;
- 7.9.3.зэрэглэл III.

7.10.Зэрэглэл I төсөлд 5 жил, зэрэглэл II төсөлд 10 жил тутамд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийх бөгөөд зэрэглэл III төсөлд энэ хуулийн 7.11-д заасан нөхцөл үүсээгүй тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийхийг шаардахгүй.

7.11.Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.10-т заасан хугацааг харгалзахгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.

7.12.Энэ хуулийн 7.7-д заасны дагуу баталсан нөлөөллийн үнэлгээ хийх төслийн ангилалд заагаагүй төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй.

7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичиг, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээтэй холбоотой хүсэлтийг тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.

7.14.Сум, дүүргийн Засаг дарга нь төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 10 хоногт багтаан хариу өгөх бөгөөд энэ хугацаанд шийдвэрлээгүй тохилдолд хариу өгсөнд тооцно.

7.15.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 7.13-т зааснаас бусад бичиг баримт шаардахгүй.”

5/8 дугаар зүйлийн 8.4.10 дахь заалт:

“8.4.10.энэ хуулийн 8.4.8-д заасан танилцуулгын үнэн зөвийг төсөл хэрэгжүүлэгч, тухайн нарийвчилсан үнэлгээг хийсэн мэргэжлийн эрх бүхий байгууллага хариуцна.”

6/8 дугаар зүйлийн 8.9, 8.10, 8.11 дэх хэсэг:

“8.9.Үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх шаардлагатай байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх төслийг энэ хуулийн 7.7-д заасан үнэлгээ хийх төслийн ангилалаар зохицуулна.

8.10.Үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр зааснаас бусад төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд шинжилгээ хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг ерөнхий шинжээч ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

8.11.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хэрэгжилтэд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг хийлгэнэ.”

7/10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг:

“10.7.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг цахим хэлбэрээр хүлээн авч, холбогдох шинжилгээг хийнэ.”

8/14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.5. дахь заалт:

“14.1.4.иргэний хүсэлтийн дагуу тухайн төслийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах;

14.1.5.хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүний нэмэлт тодотгол болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангана.”

9/17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг:

“17.2.Олон улсын банк, санхүүгийн байгууллагын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бодлого, журмын хүрээнд хийж гүйцэтгэсэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан нь энэ хуулийн 7.1, 7.2, 7.3, 8.2, 8.4, 10.1, 10.5-д заасан шаардлагыг хангасан бол хүлээн авч, 7.4-т заасан дүгнэлт, 10.4-т заасан шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж болно.”

10/18 дугаар зүйлийн 18.6, 18.7 дахь хэсэг:

“18.6.Засаг дарга энэ хуулийн 18.5-д заасан иргэний хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 15.6-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

18.7.Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.”

2 дугаар зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “үнэлгээ гэж” гэсний дараа “зэрэглэл I, зэрэглэл II” гэж, 3.1.5 дахь заалтын “төслүүдээс” гэсний дараа “байгаль орчин,” гэж, 8 дугаар зүйлийн 8.4.6 дахь заалтын “үзүүлэлтүүд,” гэсний дараа “биологийн олон янз

байдлыг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “стратегийн” гэсний дараа “болон хуримтлагдах нөлөөллийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:

“3.1.6.“байгаль орчны нөлөөллийн үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад төслийн нөлөөлөлд өртөх бүсийн байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй нөлөөлөл, цар хүрээ, үр дагаврыг төслийн үе шатуудад урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг тогтоохыг;”

2/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

“5.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэж, Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө уг үнэлгээний тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.”

3/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:

“7.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник эдийн засгийн үндэслэл, эскиз зураг, бизнес төлөвлөгөө, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, эсхүл төлөв байдлын тодорхойлолт, тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал, холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.

4/7 дугаар зүйлийн 7.6, 7.7 дахь хэсэг:

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгох бөгөөд шинжээчийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах үүрэг бүхий ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх шаардлагыг хангасан байна.

7.7.Нөлөөллийн үнэлгээний журам, үнэлгээ хийх төслийн ангиллыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, ангилалд байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадлагаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьяалал, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол,

нийгмийн нөлөөллийн болон эрүүл мэндийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг тусгана.”

5/8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт:

“8.4.8.энэ хуулийн 10.5-д заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн саналыг тусгасан байдал, танилцуулга;”

6/8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг:

“8.7.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчны мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална.”

7/9 дүгээр зүйлийн 9.2, 9.4 дэх хэсэг:

“9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэ хуулийн 7.9-д заасан ангиллаас хамааран 10 хүртэлх жилийн хугацаагаар батлах бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

9.4.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

8/9 дүгээр зүйлийн 9.6 дэх хэсэг:

“9.6.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт болон дүйцүүлэн хамгаалал хийх, хүлэмжийн хийг бууруулах талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого арга хэмжээг тусгаж тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.”

9/10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсэг:

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэх болон үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

10.5.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.”

10/14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалт:

“14.1.2. байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг төсөл хэрэгжих орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч иргэд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах;”

11/18 дугаар зүйлийн 18.4, 18.5 дахь хэсэг:

“18.4.Тухайн төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулах, санал авах шаардлагатай байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийг энэ хуулийн 7.7-д заасан үнэлгээ хийх төслийн ангиллаар батална.

18.5.Тухайн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь байгаль орчны үнэлгээний мэдээллийн санд олон нийтэд нээлттэй байрших бөгөөд иргэн газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргах эрхтэй.”

4 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсгийн “байгаль орчны” гэснийг “байгаль орчин, нийгмийн” гэж, 9 дүгээр зүйлийн 9.15 дахь хэсгийн “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “18 өдөрт” гэснийг “15 өдөрт” гэж, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “18 өдөрт” гэснийг “15 өдөрт” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “аливаа” гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилалыг бүхэлд нь хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**“БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”
ХУУЛИЙН ТӨСӨЛД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ҮНДЭСЛЭЛ**

№	Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зүйл, хэсэг, заалт	Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн төслийн зүйл, хэсэг, заалт	Шинэчилсэн үндэслэл, тайлбар
1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд дор дурьдсан зүйл, хэсэг, заалт нэмэх.			
1/3 дугаар зүйлийн 3.1.12, 3.1.13 дахь заалт:			
1.		“3.1.12.“байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт” гэж энэ хуулийн 7.9.3-д заасан зэрэглэлд хамаарах төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнөх төслийн байршлын байгалийн нөхцөл, орчны онцлогийг тогтоохыг;	Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулинд “байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт”-ыг жижиг төслүүдэд төрийн байгууллага гаргахаар заасан боловч хуулийн нэр томъёоны тодорхойлолт байхгүй тул тодорхой болгосон.
2.	Шинээр заалт нэмэх	3.1.13.“байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол” гэж төслийн хүчин чадал, технологи, байршил, талбайн хэмжээ өөрчлөгдсөн, хуулиар тогтоосон хугацаа дуусгавар болсон тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг шинэчлэхийг,”	Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулинд “байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол” хийхээр заасан боловч ямар тохиолдолд хийх нь тодорхой бус байсныг тодорхой болгосон.
2/4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг:			
3.	Шинээр заалт нэмэх	“4.4.Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”	Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журамд ерөнхий байдлаар оруулсныг салгаж мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн оролцоо, хариуцлагыг илүү тодорхой болгож тусад нь батлуулахаар тусгасан.
3/6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэг:			
4.	Шинээр заалт нэмэх	“6.7.Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолтыг төсөл хэрэгжүүлэгч	Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолтыг төрийн захиргааны

	хариуцан гүйцэтгэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.14-д заасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санд бүртгүүлнэ.	байгууллага гаргаж өгдөг байсныг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн хавсралтыг шинэчлэхтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч өөрийн үйл ажиллагааны байгаль орчны төлөв байдлыг өөрөө тодорхойлж цахим мэдээллийн санд бүртгэхээр тусгасан.
5.	6.8.Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж буй төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хянах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.	Хуримтлагдах нөлөөллийг мэргэжлийн байгууллагаас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүний нэмэлт тодотгол болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж үр дүнг тооцож байхаар тусгасан. Мөн хариуцах нэгжийг тодорхой болгож өгсөн.
6.	“6.9.Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг тодорхой бүс нутаг, сав газарт хийлгэх хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.”	
4/7 дугаар зүйлийн 7.8, 7.9, 7.10, 7.11, 7.12, 7.13, 7.14, 7.15 дахь хэсэг:		
7.	Шинээр заалт нэмэх	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлалыг шинэчлэн нийгмийн нөлөөллийн үнэлгээний аргачлалыг тусган Засгийн газар баталдаг байсныг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар оруулсан.
8.		Хуулийн хавсралтад заасан ангилалыг илүү нарийвчлан байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл цар хүрээгээр нь

	дараахь байдлаар ангилна: 7.9.1.зэрэглэл I; 7.9.2.зэрэглэл II; 7.9.3.зэрэглэл III.	ангилж зэрэглэл тогтоож өгснөөр бүх төсөлд үнэлгээ хийх шаардлагагүй болно. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санд бүртгэгдсэн төслүүдэд шинэчилсэн ангиллын төслөөр урьдчилсан байдлаар шинжилгээ хийхэд ойролцоогоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх шаардлагатай төслүүдийн 26.1 хувь нь нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагагүй, 10.2 хувь нь зөвхөн шалгах хуудсаар бүртгүүлэх боломжтой болж, нөхцөл болзолтойгоор хийх ерөнхий үнэлгээний дүгнэлтийн 31.6 хувь нь үнэлгээ хийлгэх шаардлагагүй болох судалгаа гарсан.
9.	7.10.Зэрэглэл I төсөлд 5 жил, зэрэглэл II төсөлд 10 жил тутамд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийх бөгөөд зэрэглэл III төсөлд энэ хуулийн 7.11-д заасан нөхцөл үүсээгүй тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийхийг шаардахгүй.	Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.10-д заасан хугацааг харгалзахгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.
10.	7.11.Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.10-д заасан хугацааг харгалзахгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.	Төслийн хүчин чадал нэмэгдсэн, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд одоогийн хуулиар үнэлгээ эхнээс нь хийдэг байсныг хөнгөвчилж зөвхөн нэмэлт тодотголын хүрээнд үнэлгээ хийхээр өөрчилсөн.
11.	7.12.Энэ хуулийн 7.7-д заасны дагуу нөлөөллийн үнэлгээ хийх төслийн ангилалд заагаагүй төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ шаардахгүй.	Төсөл хэрэгжүүлэгч Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтэд Засаг даргын санал авахад тодорхой хугацаа шаарддаггүй, төсөл хэрэгжүүлэгчээс саналд ач холбогдолгүй янз бүрийн нэмэлт материал шаарддаг зэрэг асуудлыг хянан үзээд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахад сум, дүүргийн Засаг даргын санал өгөх хугацаа, шаардах бичиг баримтыг тодорхой зааж өгсөн.
12.	7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичиг, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээтэй холбоотой хүсэлтийг тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.	
13.	7.14.Сум, дүүргийн Засаг дарга нь төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 10 хоногт багтаан хариу өгөх бөгөөд энэ хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд хариу өгсөнд тооцно.	
14.	7.15.Сум, дүүргийн Засаг дарга энэ	

		хуулийн 17.13-т зааснаас бусад бичиг баримт шаардахгүй.”	
5/8 дугаар зүйлийн 8.4.10 дахь заалт,			
15.	Шинээр заалт нэмэх	“8.4.10.энэ хуулийн 8.4.8-д заасан танилцуулгын үнэн зөвийг төсөл хэрэгжүүлэгч, тухайн нарийвчилсан үнэлгээг хийсэн мэргэжлийн эрх бүхий байгууллага хариуцна.”	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх олон улсын туршлагыг дагуу төслийн нөлөөлөлд өртөх этгээдэд танилцуулгыг үнэн зөв хийсэн эсэхээ төсөл хэрэгжүүлэгч, мэргэжлийн байгууллага хариуцахаар зааж хариуцлагыг тодорхой болгосон.
6/8 дугаар зүйлийн 8.9, 8.10, 8.11. дэх хэсэг:			
16.		“8.9.Үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх шаардлагатай байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх төслийг энэ хуулийн 7.7-д заасан үнэлгээ хийх төслийн ангилалаар зохицуулна.	Одоогийн хуулиар бүх үнэлгээг мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулж байгааг багасгаж 7.7-д заасан ангиллын дагуу шаардлагатай төслийг оруулахаар тусгаж, бусад нарийвчилсан үнэлгээг үнэлгээний шинжээчийн саналыг үндэслэн ерөнхий шинжээч батлахаар зааж хугацааг тодорхой болгосон. Түүнчлэн жилд 600-700 үнэлгээ зөвлөлийн хурлаар орж байгаа бөгөөд дээрх төслүүдийн 30-40 хувь нь заавал хэлэлцүүлэх шаардлагагүй төслүүд эзэлж байна.
17.	Шинээр заалт нэмэх	8.10.Үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр зааснаас бусад төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд шинжилгээ хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг ерөнхий шинжээч ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.	
18.		8.11.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хэрэгжилтэд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг хийлгэнэ.”	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилт, үнэлгээ хэр оновчтой хийгдэж, сөрөг нөлөөллийг бууруулж чадаж байгаа эсэхийг буцаагаад байгаль орчны аудитаар хянадаг тогтолцоог тодотгож өгсөн.
7/10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг:			
19.	Шинээр заалт нэмэх	“10.7.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг цахим хэлбэрээр хүлээн авч, холбогдох	Цахим шилжилт хийх хууль, эрх зүйн орчны бүрдүүлэх бодлогод нийцүүлсэн. Одоогийн хуулиар батлагдсан төслийг 4

	шинжилгээг хийнэ.”	хувь хэвлэж архивт цаасан хэлбэрээр хадгалдаг байсан бол цахимжуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заавал өөрийн биеэр ирэх шаардлагагүй болж цаг, цаас хэмнэсэн.
8/14 дүгээр зүйлийн 14.1.4. 14.1.5 дахь заалт:		
20.		14.1.4.иргэний хүсэлтийн дагуу тухайн төслийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах.
	Шинээр заалт нэмэх	14.1.5.хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүний нэмэлт тодотгол болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангана.
21.		Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулиар хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийх талаар заасан боловч хэрэгжилтийг хэрхэн хангах нь тодорхойгүй тул тайлагнах ажлыг тодорхой болгосон.
9/17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг:		
		Олон улсын банк санхүүгийн байгууллагаас санхүүжилт, зээл олгохдоо өөрийн мөрддөг шаардлага, стандартаар болон Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу 2 баримт бичиг хийгддэг. Хуулийн өөрчлөлтөөр энэ заалтыг нэмснээр давхардуулж 2 баримт бичиг хийгддэг асуудал шийдэгдэх юм.
23.	Шинээр заалт нэмэх	“17.2.Олон улсын банк, санхүүгийн байгууллагын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бодлого, журмын хүрээнд хийж гүйцэтгэсэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг энэ хуулийн 7.1, 7.2, 7.3, 8.2, 8.4, 10.1, 10.5-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд дүйцүүлэн хүлээн авч мөн хуулийн 7.4-д заасан дүгнэлт, 10.4-д заасан шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж болно.”

10/18 дугаар зүйлийн 18.6, 18.7 дахь хэсэг:		
24.	Шинээр заалт нэмэх	18.6.Засаг дарга энэ хуулийн 18.5-д заасан иргэний хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 15.6-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй. 18.7.Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.”
25.		Үндсэн хуулийн 6.2 дахь заалтад нийцүүлэн иргэдийн мэдэх эрхийг баталгаажуулж тусгаж өгсөн.
2 дугаар зүйл. Үг нэмэх		
26.	Шинээр үг нэмэх	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “үнэлгээ гэж” гэсний дараа “зэрэглэл I, зэрэглэл II” гэж, 3.1.5 дахь заалтын “төслүүдээс” гэсний дараа “байгаль орчин,” гэж, 8 дугаар зүйлийн 8.4.6 дахь заалтын “үзүүлэлтүүд,” гэсний дараа “биологийн олон янз байдлыг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “стратегийн” гэсний дараа “болон хуримтлагдах нөлөөллийн” гэж тус тус нэмсүгэй.
3 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах		
1/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:		

27.	3.1.6. "байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад хэрэгжүүлэх явцад байгаль орчинд орчинд болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;	3.1.6. "байгаль орчны нөлөөллийн үнэлгээ" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад төслийн нөлөөлөлд өртөх бүсийн байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй нөлөөлөл, цар хүрээ, үр дагаврыг төслийн үе шатуудад урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг тогтоохыг;	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэр томъёоны агуулгад нийгмийн нөлөөллийн асуудлыг давхар тусгаж байгааг тодорхойлж өгсөн.
2/5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт			
28.	5.1.Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч салбарын яам нь уг баримт бичгийг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэж, Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө уг үнэлгээний бодлогын баримт бичгийн төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.	5.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэж, Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө уг үнэлгээний тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуультай нийцүүлэн нэмэлт оруулсан.
3/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:			
29.	7.3.Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн	"7.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник эдийн засгийн үндэслэл, эскиз зураг, бизнес төлөвлөгөө, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, эсхүл төлөв байдлын тодорхойлолт, тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал, холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн	Төслийн ангиллын дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх харьяаллыг тодорхой болгож өгсөн.

	захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлтэнэ.	захиргааны төв байгууллага, эсхүл аймаг нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.	
4/7 дугаар зүйлийн 7.6, 7.7 дахь хэсэг:			
30.	7.6.Үнэлгээний шинжээч болон тэдгээрийн үйл ажиллагааг удирдан зохицуулах ерөнхий шинжээчийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно.	“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг Засгийн газрын гишүүн олгох бөгөөд шинжээчийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлага болон шаардлагыг хангасан байна.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий шинжээч, ерөнхий шинжээчийг томилох, ерөнхий шинжээчид тавигдах шаардлагыг тодорхой болгож өгсөн.
31.	7.7.Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана.	7.7.Нөлөөллийн үнэлгээний журам, үнэлгээ хийх төслийн ангиллыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, ангилалд байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадлагаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьяалал, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн болон эрүүл мэндийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг тусгана.”	Одоогийн хуулийн хавсралтаар баталж байсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх ангиллыг Засгийн газраар батлуулахаар тусгаж, нөлөөллийг үнэлгээний журамд орох асуудлын хамрах хүрээг тодорхой болгож өгсөн.
5/8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалт:			
32.	8.4.8.Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн	“8.4.8.энэ хуулийн 10.5-д заасны дагуу төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн саналыг тусгасан байдал, танилцуулга”	Төслийн нөлөөлөлд өртөгч иргэдээс санал авахдаа тухайн баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж саналыг

	нийтийн хурлын санал, тэмдэглэл;		тогтоолоор албажуулдаг байсныг олон улсын жишгийг даган зөвхөн танилцуулга, хэлэлцүүлгийн тайланг нарийвчилсан үнэлгээнд тусгадаг болгосон.
6/8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг:			
33.	8.7.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь хээрийн судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг байгаль орчны мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална.”	“8.7.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг байгаль орчны мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална.”	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, “Алсын хараа - 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлттэй холбогдуулан төрийн бүх шатны үйл ажиллагааг цахимжуулах ажлыг баталгаажуулсан. Цахим болгосноор цаг хугацаа, цаас хэмнэдэг болгосон.
7/9 дүгээр зүйлийн 9.3, 9.4 дэх хэсэг:			
34.	9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.	“9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэ хуулийн 7.9-д заасан ангиллаас хамааран 10 хүртэлх жилийн хугацаагаар батлах бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.	Одоогийн хуулиар төслийн цар хүрээ, сөрөг нөлөөллийг харгалзахгүй бүх төсөл 5 жилийн хугацаатай байсныг төслийн ангиллаас хамааруулан ялгаатай болгож өгсөн. Ингэснээр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батлуулах төсөл 50 хувиар буурна. Хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулах гэснийг хянах, батлах, тайлагнах гэж хүрээг нь тодорхой болгож
35.	9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн	9.4.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”	

	стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батална.		журмыг батлах харьяаллыг тогтоосон.
8/9 дүгээр зүйлийн 9.6 дэх хэсэг:			
36.	9.6.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.	“9.6.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт болон дүйцүүлэн хамгаалал хийх, хүлэмжийн хийг бууруулах талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого арга хэмжээг тусгаж тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.”	“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-нд орох асуудлын хамрах хүрээг илүү нарийвчилж тодорхой болгосон.
10/10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсэг:			
37.	10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.	“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэхийг харгалзан, үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.	Баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын саналыг тогтоолоор хэрэгжүүлдэг байсныг олон улсын жишгийг даган төсөл хэрэгжүүлэгч, мэргэжлийн байгууллагын нөлөөлөлд өртөх баг хорооны иргэдээс авсан танилцуулга, хэлэлцүүлгийн тайланг нарийвчилсан үнэлгээнд тусгадаг болсноор Иргэдийн Нийтийн Хурал хуралдахгүй удах, төслийг гацаах асуудлыг багасгаж өгнө.
38.	10.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна.	“10.5.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.”	
11/14 дүгээр зүйлийн 14.1.2 заалт			

39.	14.1.2.байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орчин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах;	“14.1.2. байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг төсөл хэрэгжих орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч иргэд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах;”	Төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн мэдэх эрхийг баталгаажуулж өгсөн.
12/18 дугаар зүйлийн 18.4, 18.5 дахь хэсэг:			
40.	18.4.Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна	“18.4.Тухайн төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулах, санал авах шаардлагатай байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэх төслийг энэ хуулийн 7.7-д заасан үнэлгээ хийх төслийн ангиллаар батална.”	Хуулийн төслийн хүрээнд бүх төслийн нөлөөлөлд өртөх баг, хорооны иргэдээс санал авдаг байсныг хязгаарлаж зөвхөн зэрэглэл I заасан ангиллын төсөлд авахаар тусгасан.
41.	18.5.Олон нийтийн оролцооны асуудлыг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“18.5.Тухайн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь олон нийтэд нээлттэй мэдээллийн санд байрших бөгөөд иргэн газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргах эрхтэй.”	
4 дүгээр зүйл. Үг өөрчилсөн.			
42.	Хүчингүй болгох	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсгийн “байгаль орчны” гэснийг	

		"байгаль орчин, нийгмийн" гэж, 9 дүгээр зүйлийн 9.15 дахь хэсгийн "байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн" гэж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн "18 өдөрт" гэснийг "15 өдөрт" гэж, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн "18 өдөрт" гэснийг "15 өдөрт" гэж тус тус өөрчилсүгэй.	
5 дугаар зүйл. Үг хассан			
43.	Үг хассан	5 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын "аливаа" гэснийг хассугай.	
6 дугаар зүйл. Хүчингүй болгох			
44.	Хүчингүй болгох	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилалыг бүхэлд нь хүчингүй болсонд тооцугай.	
7 дугаар зүйл. Хүчин төгөлдөр мөрдөх			
45.	Хүчин төгөлдөр мөрдөх	Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“7.ХЭЛЭЛЦСЭН нь: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025. 04. 18 № 01/3019

танай _____-ны № _____-т

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД С.ОДОНТУЯА ТАНАА**

Таны 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/1613 тоот албан бичгээр ирүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000743



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.04.10 № 1/1874

танай 2025.04.04-ны № 01/1614 -т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД С.ОДОНТУЯА
ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар
зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Байгаль орчинд
нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их
Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.




О.АЛТАНГЭРЭЛ

15180004
А5 файл 2025

02166 0101500
 قمتس قمتس
 و قمتس و قمتس

فَتَحْنِيحُ مَحْمَدُ بْنُ سُلَيْمَانَ بْنِ مَحْمُودٍ
لَهُ مَحْمُودُ بْنُ سُلَيْمَانَ بْنِ مَحْمُودٍ

رسمين مصحفين در مفسر رسمين در ۵۰ فمسن دند م
۱۰۵۰ فرد رسد مو خنفسير و مستنق و فمسنين مفسر مو فمفسير
و دند م فمفسير و مفسر رسمين فو نسيم . مفسر مفسير
مفمفسير مفسر رسمين در مفسر ن مفسر م كسا مفسر فو مفسر
مفسر ن فمسن رسو مفسر ..





БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

ААН	Аж ахуй нэгж
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОСҮ	Байгаль орчны стратегийн үнэлгээ
БОТБҮ	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
БОНЕҮ	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ
БОНБҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБҮтХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
БОНҮМЗ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний мэргэжлийн зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:	2
УДИРТГАЛ	4
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	4
1.2. Үнэлгээ хийх хүрээ	7
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	7
1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур	8
1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур	8
1.4. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	9
1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	10
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	12
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	13
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:	13
3.2. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	17
1.1. Үнэлэлт, дүгнэлт	27
1.2. Зөвлөмж	27
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	30

.

УДИРТГАЛ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” (БОНБҮтХ)¹ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулах зорилтын хүрээнд 2012 онд “5 бүлэг, 20 зүйл” бүхий бүтэцтэй шинэчлэн найруулж, батлуулан хэрэгжүүлж байна.

Байгаль орчны салбарт 2009-2012 онд хийгдсэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд салбарын үндсэн харилцааг зохицуулж байсан 33 хуулиас 18 хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган, бодлогын хувьд шинэ агуулга, зохицуулалтаар шинэчилсэн ба энэхүү эрх зүйн шинэчлэлийн хүрээнд уг хуулийг шинэчилсэн найруулгаар УИХ-аас баталсан. БОНБҮтХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хууль (2015) болон “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын (2016) дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамны “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” чиг үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх зөвлөх баг хийж гүйцэтгэлээ.

Хэрэгжилтийн үр дагаврын энэхүү үнэлгээ нь нийт 11 зүйл, хэсэгт хамаарах 8 зөвлөмжийг боловсруулсанаас гадна уг хуулийн харилцаанд оролцогч субъектуудээс холбогдох мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн төрийн бус байгууллага /Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо ТББ, Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо ТББ, Монголын Банкны Холбоо ТББ, Байгаль орчны мэргэжилтнүүдийн Холбоо ТББ, Уул уурхайн эрх зүй судлалын сан ТББ г.м/, үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгжийн төлөөлөл, мэргэжилтэн, удирдлагатай уулзалт, ярилцлага зохион байгуулж, мэдээлэл цуглуулж ажилласан болно.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал (цаашид “Аргачлал” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

БОНБҮтХ нь 1998 онд анх батлагдаж, 2012 онд шинэчлэн найруулж батлуулснаар 30-аад жил мөрдөж байгаа бөгөөд 2015, 2017, 2022, 2023 онуудад 4 удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан боловч Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу уг хуульд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ¹ хийгдэж байгаагүй байна.

Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 2012 оноос эхлэн олон хууль тогтоомж мөрдөгддөг зарим салбарын түүний дотор байгаль

¹ Хууль тогтоомжийн тухай хууль, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” хэмээн заасан байна.

орчны салбарын хуулиудад кодификац хийх, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилтыг тавьж Хууль зүй дотоод хэргийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын (хуучин нэрээр) А/371, А/313 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан ажлын хэсгийг 2017 онд байгуулан, салбарын 30 хуульд зөрчил, давхардал, хийдлийн шинжилгээг хийж, нийт 96 давхардал, 335 хийдэл, 164 зөрчил байна гэж тогтоон, тэдгээрийг засаж сайжруулахаар нэмэлт өөрчлөлт хийх төслийг боловсруулан, УИХ-д өргөн мэдүүлсэн. Дээрх багц хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг 2022 онд Засгийн газар эргүүлэн татаж, өнөө үед үүсч бий болсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагын дагуу дахин боловсруулж, өргөн мэдүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээндээ Отгонтэнгэр их сургууль, Монгол улсын их сургуулийн эрдэмтэд судлаачдын багаар хууль эрх зүйн нарийвчилсан шинжилгээ хийлгэж, хийдэл давхардал, зөрчлийг арилгах, эрх зүйн хувьд боловсронгуй болгох өргөн хүрээтэй судалгааны ажлыг хийсэн.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.3-т заасан “хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх зорилт”-ын хүрээнд 2021-2030 онд “Цахим хэлбэрт шилжсэнээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ шат дамжлагагүй, шуурхай болно” гэж, мөн зорилт 6.2-т заасан “байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилт”-ын хүрээнд 2021-2030 онд “Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийнэ” гэж тус тус заасан бөгөөд салбарын төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй хүргэх замаар байгаль орчныг хамгаалах тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн байна.

УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 30-д “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбогдсон зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт”-ыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.3-т “Цахим Монгол арга хэмжээний хүрээнд зөвшөөрлийн цахим бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрөөс олгох зөвшөөрлийн тоог цөөлж, олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно” гэж, 5.1-т “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх” гэж салбарын төрийн үйлчилгээг тодорхой, шуурхай, давхардал, чирэгдэлгүй хүргэх замаар байгаль орчныг хамгаалах үндсэн зорилтуудыг тодорхойлсон байна.

Мөн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Ногоон хөгжлийн сэргэлтийн 5.4-т “Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон

хөгжлийн жишиг загварыг тодорхойлно” гэж, Төрийн бүтээмжийн сэргэлтийн 6.1-т “Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна” гэж, мөн тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.1-т “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байгаль орчны хяналт, шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгон хэрэгжүүлэх” гэж тус тус заасан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын (хуучин нэрээр) 2021 оны А/56 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-нд БОНБУТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан бөгөөд Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийн 7 дахь хэсгээр “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эрх зүйн орчныг шинэчлэх асуудлыг хөндөн БОНБУТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг үүрэг болгожээ.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх журам”, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”, Байгаль орчин, ногоон хөгжлийн (хуучин нэрээр) Сайдын 2014 оны А-03 дугаар тушаалаар “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”, А-04 дүгээр тушаалаар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”, А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг тус тус батлан уг хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ч БОНБУТХ болон эдгээр журмуудын хэрэгжилт өнөө цаг үеийн хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцэхгүй байгаа талаар салбарын болон салбарын бус төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон нийтээс удаа дараа үндэслэл бүхий саналыг гаргасаар байна.

Ийнхүү БОНБУТХ-ийг хэрэгжүүлсэн өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд хуулийн зарим зүйл, заалт хоорондоо зөрчилдөх, зохицуулалтын хувьд давхцах, тодорхой бус хоёрдмол утга илэрхийлэх, төсөл хэрэгжүүлэгчдэд эдийн засгийн болон цаг хугацааны хүндрэл бэрхшээл үүсгэж байгаа тул эдгээр асуудлыг эрх зүйн зохицуулалтын хувьд сайжруулан зохицуулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлох “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, байгаль орчны салбарт ногоон хөгжлийг эрхэмлэн, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган, үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулах зорилт тавьсан. Бодлогын энэ томоохон шинэчлэл нь эрх зүйн орчинд нилээдгүй өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бөгөөд зарим зорилтууд нь одоогийн мөрдөж байгаа эрх орчинд амжилттай хэрэгжих боломжгүй, өмнө байсан бодлогын сарнимал тогтолцоо, түүнийг дэмжсэн эрх зүйн орчин нь шинээр эмхэтгэгдэн тавигдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл үүсгэх болсон байна.

Иймээс Монгол Улсын ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэн 30 жилийн туршлагаас авсан сургамж, олон улсын нийтлэг жишиг, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зөвлөмжүүдийг харгалзан одоо мөрдөж байгаа БОНБҮтХ-ийн өнөөгийн зохицуулалтыг нийцүүлэх, уялдааг хангах, боловсронгуй болгон сайжруулж тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодит хэрэгцээ, шаардлага үүссэн байгаа учир БОНБҮтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт энэхүү үнэлгээг хийсэн.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан байна.

Монгол Улсын иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглах үйл ажиллагааг зохицуулах үндсэн арга механизм нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоотой салшгүй холбоотой бөгөөд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр дамжуулан байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах бодлогыг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах” заасны хүрээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь аливаа төслийг хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчныг хамгаалах, байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхийн зэрэгцээ төслийг хэрэгжүүлэх эсэх талаар холбогдох шийдвэр гаргалтад олон улсад хамгийн түгээмэл хэрэглэгддэг, байгаль орчны бодлого, хууль тогтоомжийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчны төлөвлөлт болон менежментийн арга хэрэгсэл юм. Иймд БОНБҮтХ-ийн 5, 6, 7, 8, 9, 10, 14, 17, 18, 19, 20 дугаар зүйлүүдэд болон тэдгээрт холбогдох зохицуулалтуудыг үнэлгээ хийх хүрээнд хамруулах нь зүйтэй гэж үзлээ.

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтүүдээс дараах 2 шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

Аргачлалын 3.4.1-т заасан “зорилгод хүрсэн түвшин”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хувьд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоох, аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль

тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх зэргийг тодорхойлно.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур

Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоохыг зорьдог. БОНБҮТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах..., ... оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино” гэж заасан.

2019 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн хоёр дах хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн, Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ, Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй, Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”² гэж заажээ.

БОНБҮТХ-ийн зорилт нь бүхэлдээ Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 6.2 дах хэсгийг хэрэгжүүлж чадаж буй эсэх /мөн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дах хэсэг болон Байгаль орчныг хамгаалах тухай хууль/ буюу байгаль орчныг хамгаалан иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг бүрэн хангаж, зорилтдоо хүрч чадаж буй эсэхийг, түүнчлэн БОНБҮТХуулийн зорилт хангагдахад уг хуулийн зарим нэг зүйлийг хамтад нь шалгахын тулд уг хуулийн дараах 2 зүйлийг сонгосон болно.

Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр тодорхойлбол:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд.

№	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1.	5 дугаар зүйл	Байгаль орчны стратегийн үнэлгээ
2.	18 дугаар зүйл	Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур

БОНБҮТХууль нь хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөлх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулдаг ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний төрөл, ангиллуудын хүрээнд төрийн захиргааны төв болон орон нутгийн

² “Төрийн мэдээлэл” эмхэтгэл (1992), №1

захиргааны байгууллага, эрх бүхий мэргэжлийн байгууллаг, бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийн оролцоог ханган хэрэгждэг байна.

БОНБҮтХ нь 2012 онд шинэчилсэн найруулгаар батлагдсанаас хойш уг хуулийн хэрэгжилтийн зарим нэг тоон мэдээллийг дурдвал:

✓ 2025 оны 03 дугаар сарын байдлаар нийт 12938 ерөнхий үнэлгээний дүгнэлтийг боловсруулсан;

✓ 2025 оны 03 дугаар сарын байдлаар 7866 нарийвчилсан үнэлгээний тайланг баталгаажуулсан бөгөөд эдгээрийн 6583 нь Үндсэн тайлан, харин 1283 нь Нэмэлт тодотгол байна.

✓ Асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь 9 шинжээч, 1 ерөнхий шинжээчийн хүний нөөцтэйгөөр ажилладаг;

✓ Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянасан байдлыг сүүлийн 3 жилээр байдлаар авч үзвэл 2018 онд 114, 2019 онд 215, 2020 онд 140, 2021 онд 94, 2022 онд 161, 2023 онд 54 менежментийн төлөвлөгөөг хянасан;

✓ Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 175 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг. Иймд:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд БОНБҮтХ тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг тул дараах зүйл, хэсэг, заалтыг уг шалгуурын хүрээнд сонгосон болно.

Хүснэгт 2. Практикт нийцэж буй байдал, шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл заалтууд

Д/д	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1.	6 дугаар зүйл	Төлөв байдал болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ
2.	7 дугаар зүйл	Нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх эрх бүхий байгууллага
3.	8 дугаар зүйл	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
4.	9 дүгээр зүйл	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
5.	10 дугаар зүйл	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
6.	14 дүгээр зүйл	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үүрэг
7.	17 дугаар зүйл	Банк санхүүгийн болон хөрөнгө оруулалтын байгууллагын үүрэг
8.	19 дүгээр зүйл	Хууль зөрчигчид хүлээх хариуцлага
9.	20 дугаар зүйл	Хохирлыг нөхөн төлүүлэх

1.4. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Энэхүү үнэлгээг хийхэд “зорилгод хүрсэн түвшин” болон “практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг сонгож авсан болно.

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараахь асуултуудыг боловсрууллаа.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1.БОНБҮтХ-ийн 5 дугаар зүйл. “Байгаль орчны стратегийн үнэлгээ” нь Монгол Улсын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг “боловсруулах, хянах, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, мониторинг хийгдэх” явцад хэрэгжсэн эсэх;

2.БОНБУТХ-ийн 18 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо хангалттай түвшинд байгаа эсэх, олон нийтийн оролцоогоо хэнээр дамжуулан хангах, олон нийт шаардлагатай гэж үзвэл төрийн байгууллагаас дамжихгүйгээр төсөл хэрэгжүүлэгчээс холбогдох мэдээллийг хуулийн хүрээнд авч болох эсэх;

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- БОНБУТХ-ийн 6 дугаар зүйл: Аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлж, хянуулахад төлөв байдлын нөлөөллийн үнэлгээний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

- Мөн тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлэ байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилга арга хэмжээ тогтоож, хянуулахад хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

- Түүнчлэн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажилд шаардагдах зардлыг нөлөөллийн цар хүрээг харгалзан төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулах, эрх бүхий мэргэжлийн Эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулах явдал хэр бодитой хэрэгжиж байна вэ?

- БОНБУТХ-ийн 7 дугаар зүйл. Иргэн аж ахуй нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтооход нөлөөллийн үнэлгээний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

- БОНБУТХ-ийн 8, 10 дугаар зүйл: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

- БОНБУТХ-ийн 9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

- БОНБУТХ-ийн 14 дүгээр зүйл. Стратегийн үнэлгээ хийх байгууллага тодорхой туссан эсэх, чиг үүргийг оновчтой хуульчлаагүйгээс ямар асуудал үүсч байна вэ?

- БОНБУТХ-ийн 17 дугаар зүйл. Банк, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын байгууллагын үүрэгт холбогдох зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

- БОНБУТХ-ийн 19 болон 20 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага нь үр ашигтай, үр нөлөө бүхий байж чадаж байгаа эсэх, байгаль орчны хохирол нөхөн төлүүлэх механизмын суурь зохицуулалт оновчтой хуульчлагдсан эсэх?

1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, хэсэг, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилт болон хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг

илрүүлэх зорилгоор аргачлалын 3.7.3-т тусгасан мэдээлэл дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа болон чиг үүргээрээ түүнтэй холбоотой төрийн байгууллага, албан хаагч, хуулийн хэрэгжилтэд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдээс мэдээллийг ярилцлагын аргаар ашиглах;

2. Тодорхой салбар, чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, эсхүл хууль тогтоомж хэрэгжүүлж байгаа буюу түүний хэрэгжилтэд хамаарах бусад субъектийг оролцуулсан уулзалт, ярилцлага зөвлөгөөнийг зохион байгуулан хэрэгцээтэй мэдээллээ олж авах;

3. Хууль тогтоомж хэрэгжиж байгаа орчин нөхцөлд биечлэн очиж, ажиглалт хийх болон ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулах;

4. Хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан судалгааны тайлан, статистикийн тоо баримтыг ашиглах.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

БОНБУТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ мэдээлэл цуглуулах аргуудын дагуу холбогдох мэдээлэл цуглуулах, судалгаа хийх ажлыг холбогдох материалыг цуглуулан үнэлгээг хийсэн болно.

- Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах

Хууль, эрх зүйн акт:

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012
- ✓ Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам, 2013
- ✓ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, 2013
- ✓ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам, 2014
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам, 2014
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2019
- ✓ Байгаль орчны аудит хийх эрх олгох журам, Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал, 2019

Хоёр. Бодлогын баримт бичиг:

- ✓ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Шинэ сэргэлтийн бодлого”, 2021
- ✓ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, 2020
- ✓ Монгол Улсын Засгий Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020

Гурав. Судалгааны тайлан:

- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчлэлтэд зориулсан төслийн ангиллыг боловсронгуй болгох судалгаа. Д.Шижир-Эрдэнэ, Др.И.Бямбахүү, Г.Сурахбаяр. 2022;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ: Олон улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний харьцуулсан судалгаа болон Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүний хэрэгжилт, холбогдох сайжруулах санал зөвлөмж, Др. И.Бямбахүү. 2022. НҮБХХ-ийн Байгаль орчны засаглал төсөл;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль ба холбогдох бусад хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа., БОАЖЯ, 2022;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэх механизмын бүтээмжийн үнэлгээ., БОАЖЯ, 2020;
- ✓ Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог сайжруулах нь., АМЭП төсөл, 2021;
- ✓

Дөрөв. Цахим эх сурвалж:

www.legalinfo.mn

<https://met.gov.mn/>

<https://eic.mn/>

<https://shuukh.mn/>
<https://www.parliament.mn/>
<https://amep.mn/>
<https://legalinfo.mn/mn/>
<https://www.igfmining.org/resource/environmental-social-impact-assessments-legal-frameworks-california-kazakhstan-queensland/>

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу БОНБҮТХ-аас сонгож авсан зохицуулалтуудад дараах байдлаар үнэлгээ хийлээ.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

БОНБҮТХ-ийн үндсэн зорилтыг “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино” хэмээн уг хуулийн 1 дүгээр зүйлд заажээ. Энэхүү зорилтыг хуулийн бүхий л зохицуулалт хангаж байх ёстой гэж үзсэн учир тус хуулийн 5, 18 дугаар зүйлийг сонгож авч үзсэн болно.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.

БОНБҮТХ-ийн 5 дугаар зүйл. “Байгаль орчны стратегийн үнэлгээ” нь Монгол Улсын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хянах, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, мониторинг хийгдэх явцад хэрэгжсэн эсэх?

БОНБҮТХ-ийн 5 дугаар зүйлд “улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюултай уялдуулан тодорхойлох байгаль орчны стратегийн үнэлгээ хийх”-тэй холбоотой харилцааг зохицуулсан.

БОНБҮТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.3 дэх хэсэгт “Стратегийн үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний талаарх нарийвчилсан журмыг Засгийн газар батална” гэсний дагуу Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.

Мөн БОНБҮТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, 5 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 18.3 дахь хэсгүүдэд стратегийн үнэлгээний тодорхойлолт, тус үнэлгээг хийх нарийвчилсан журам батлах, стратегийн үнэлгээг хийх, тайланг хэлэлцэж, дүгнэлтийг танилцуулах, олон нийтэд мэдээлэх, стратегийн үнэлгээнд хамрагдах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан байгууллага болон төсөл

хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг, үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хэрхэн хангах талаарх харилцааг зохицуулсан байна.

Шигтгээ. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш стратегийн үнэлгээ хийгдээгүй бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хууль, холбогдох журам, аргачлал (2013-2014) батлагдсаны дараах бүх төрийн захиргааны төв байгууллагын бодлого, хөтөлбөр хариуцсан удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад стратегийн үнэлгээ хийх талаарх сургалтыг 2013, 2015, 2018 онуудад зохион байгуулж, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, үндэсний хэмжээний төлөвлөгөө, төсөлд стратегийн үнэлгээ хийлгэх талаар Сайдын албан тоотыг тухай бүрт хүргүүлэн ажилласан байна.

УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээний тайлангаас, 2022

БОНБУтХ хэрэгжиж эхэлснээс хойш төрийн захиргааны төв байгууллагууд уг хуулийн хэрэгжилтийг хангаж өнөөг хүртэл стратегийн үнэлгээ хийлгээгүй байна. Мөн стратегийн үнэлгээ хийгдээгүй бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталдаг хууль бус жишиг тогтсон байна.

Стратегийн үнэлгээг “боловсруулах, дүгнэх, хэрэгжүүлэх, олон нийтийн санал авах, хяналт шинжилгээ, мониторинг хийх” зэргээр холбогдох зохицуулалт нь хэрэгжихгүй байгаагаас гадна Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зарим зохицуулалттай давхардах, зөрчилдөх асуудал үүсэж байж болзошгүй байна.

Шигтгээ. “Стратегийн үнэлгээний эрх зүйн орчин” сургалтын танилцуулга

- ✓ Төлөвлөгчид, шийдвэр гаргагчид болон тухайн шийдвэрийн нөлөөлөлд өртөгч олон нийтэд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бодлого, шийдвэрийн талаар мэдээлж, байгаль орчин, нийгэм, оршин суугчдад хамгийн ээлтэй хөгжлийн бодлогын хувилбарыг эрэлхийлэх, сонгох;
- ✓ ОН-д түшиглэсэн менежментийг сайжруулж ардчилсан зарчмаар шийдвэр гаргах үйл явцыг баталгаажуулах;
- ✓ Бодлого, шийдвэрийн үнэн зөвд итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг сайжруулах;
- ✓ Байгаль орчны үнэлгээ хийх боломж болон байгаль орчны талаар баримтлах зарчмыг төсөл боловсруулалтын түвшинд хангаж өгдөг.
- ✓ Бодлогын арга хэмжээний хамгийн сөрөг нөлөө багатай хувилбарыг тодорхойлох,
- ✓ Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн зорилтыг хангах хувилбаруудыг тогтоож, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангах;
- ✓ Салбарын урт хугацааны хөгжилд нөлөөлөх бүс нутгийн болон глобал асуудлуудыг урьдчилан таамаглах

БОАЖЯ, 2018 он, Улаанбаатар

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3.

БОНБУтХ-ийн 18 дугаар зүйл. “Бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх, дүгнэлт, шийдвэр гаргах”-ад олон нийтийн оролцоог хангах зорилтдоо хүрсэн эсэх?

БОНБУтХ-аар бий болсон буюу Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан иргэний эрүүл, аюулгүй орчин амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн бодит хэрэгжилт, хууль зүйн механизм болсон зарчмын шинэлэг өөрчлөлт бол байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний төрөл, ангилал тус бүрд нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчид, олон нийтээс албан ёсоор санал авах, тэдэнд

танилцуулах, зөвлөлдөх, улмаар шийдвэр гаргахад тэдний оролцоог хангах зохицуулалт бий болжээ.

БОНБУтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.5 дах хэсэгт заасны дагуу “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ыг байгаль орчны асуудал эрхэлсэн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06- ны өдрийн А-03 тоот тушаалаар баталж, байгаль орчны стратегийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хэрхэн хангах талаар тусгайлан журамласан байна.

***Шигтгээ.** Яамнаас хуулийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын саналыг тусгаагүй нарийвчилсан үнэлгээний тайлан байхгүй, харин тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжих төслийн хувьд төсөл хэрэгжих газрын Хамгаалалтын захиргаанаас саналыг авдаг байна.*

УИХ- ын Тамгын Хяналт шалгалт, үнэлгээний газар, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хvүлийн хэрэгжилтэд хяналт шинжилгээний тайлангаас, 2022

БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа нь хуульд заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөл нь үнэлгээний тайланг хэлэлцсэн талаарх багийн Иргэдийн Нийтийн хурлын тогтоол, тэмдэглэлийг гаргуулан авахад анхаарлаа хандуулж, харин хууль, журамд заасан иргэдийг мэдээллээр хангах, тэднээс урьдчилан санал авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, тайлангийн ил тод байдлыг хангах талын хэрэгжилт төдийлөн хангалттай бус байна.

БОНБУтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.4.8 хэсэг дэх “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл”зохицуулалт, шаардлагыг хэрэгжүүлэх хэлбэр буюу тухайн багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлсэн тогтоол, шийдвэрийг үнэлгээний тайланд албажуулан хавсаргах нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгж болон төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн хувьд хүндрэлтэй асуудал болсон байна.

БОНБУтХ-д заасан дээрх багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоол, тэмдэглэлийг үнэлгээний тайланд хавсаргах зохицуулалт зохих түвшинд хэрэгжиж байгаа хэдий ч иргэдийн саналыг авах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажил үр дүнтэй явагдаж, байгаль орчны шийдвэр гаргахад ач холбогдолтой мэдээллийг танилцуулах, иргэд, олон нийтийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах замаар тэдний оролцоог бүрэн хангаж чадаж байгаа эсэхэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллагууд хангалттай ажиллаж чаддаггүй байна.

Үүний нэг шалтгаан нь холбогдох хууль, журамд нутгийн захиргааны байгууллага, удирдлагын үүрэг, хариуцлагын талаар оновчтой тусгаагүйгээс үүдэн багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны тов, давтамж тодорхой бус, хурлын ирцийг бүрдүүлэхэд хүндрэл бэрхшээл гарсаар байна. Дээр дурдсан шалтгаан, нөхцөл байдал нь тухайн төслийн төлөвлөлт, явцыг удаашруулах, зогсоох, Ерөнхий үнэлгээний хугацаа дуусах, дахин сунгуулах зэрэг хүндрэл чирэгдлийг учруулдаг байна.

Шигтгээ. Булган аймгийн Шигтгээ. Булган аймгийн нутаг дэвсгэрийн 0,4 хувийг буюу 598,6 мян.га талбай бүхий ашигт малтмалын ашиглалтын 65, хайгуулын 69, нийт 134 тусгай зөвшөөрөл 2016 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр бүртгэлтэй байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулах алтны 7, барилгын 2, төмрийн 1 нийт 10 төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2012-2016 оны хооронд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох нэгжээр батлагдаж Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Дашинчилэн сумдын нутагт хэрэгжсэн байна. Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан авч үзвэл иргэдийн нийтийн хуралд 53 иргэн хүрэлцэн тохиолдолд хурал хүчин төгөлдөр болохоор байна.

Иргэдийн Нийтийн хуралд оролцогчдоос гаргасан саналууд:

Сумын төвд худалдааны зах барих - Мод үржүүлгийн газар байгуулах - Хөдөөгийн малчдад хүргэх соёлын үйлчилгээг дэмжих – Хүлэмжийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх - Спортын талбайтай болгох - Гүний худаг гаргах - Орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх - Төслийг хэрэгжүүлэхэд татгалзах зүйлгүй - Орон нутгаас ажилтан авах - Мах, сүү, цагаан идээ авч байх - Орон нутгаас ажилтан авах - Сум орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх - Тоосжилтыг багасгах тал дээр анхаарч ажиллах - Нөхөн сэргээлтийн ажилд орон нутгийн иргэдийг оролцуулах - Нэг замаар тээвэрлэлт явуулах

Багийн Иргэдийн Нийтийн хурлаар байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэлэлцүүлсэн байдалд үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний тайлангаас, БОАЖЯ, 2017

Иргэд өөрсдийн амьдарч буй нутаг орны онцлог, мэдлэг, туршлагаасаа хуваалцах, байгаль орчин болон эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд үзүүлж буй болон төсөл хэрэгжсэнээр үзүүлж болох сөрөг нөлөөллийг бууруулах талаар ач холбогдолтой санал гаргаж тусгуулах, байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээлгэх талаар хамтран ажиллахад иргэдийн оролцоо чухал байтал манай иргэд ихэнхдээ тухайн төсөл хэрэгжүүлэгчээс орон нутгийн бүтээн байгуулалт, худаг усны хангамж, хандив тусламж хүссэн санал хэлэх тохиолдол давамгайлдаг байна.

Иймд бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх, дүгнэлт, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангаж байгаа өнөөгийн хууль зүйн зохицуулалт, механизм нь амьдралд ач холбогдол, үр дүн, үр ашигтайгаар хэрэгжиж, хууль тогтоогчдоос анхлан дэвшүүлсэн зорилтдоо хүрч чадахгүй байна гэж дүгнэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10-т Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно гэж заасан байна. Судалгаанд хамрагдсан уул уурхайн төслүүдийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд авагдсан багийн Иргэдийн Нийтийн хурлын тэмдэглэлд “5-160 иргэн хуралдаанд оролцсон” гэж тусгасан нь дунджаар 53 иргэн хурал хүрэлцэн ирсэн байна. Харин Үндэсний Статистикийн Хорооны тайлан мэдээнд үндэслэн холбогдох хуулийн шаардлагын дагуу нягталж үзэхэд, дунджаар 67 иргэн хуралд хүрэлцэн ирсэн бол хурлын шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

Төслийн нөлөөлөлд шууд ба шууд бус хэлбэрээр өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэдээс багийн Иргэдийн Нийтийн Хурлын үеэр гаргасан 372 санал, хүсэлтийг тоймлож үзвэл:

1.Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах чиглэлээр: Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад санаачилгатай ажиллах, нөхөн сэргээлтийг цаг тухайд нь чанартай сайн хийх, булгийн эхийг хашиж хамгаалах, бэлчээр доройтохоос сэргийлж, нэг замаар тээвэрлэлт хийх, тоосжилтыг бууруулах, нөхөн сэргээлтэд нутгийн унаган олон наст ургамал суулгах, булаг, шандын эхийг хашиж хамгаалах, тээвэрлэлт хийхдээ зам дээр хог хаяхгүй байх болон уурхайн хог хаягдлыг тогтоосон цэгт стандартын дагуу дарж булах, хортой, аюултай хэрэглэхгүй байх, өлийн цагаан оготно устгахад хамтарч ажиллах зэрэг саналыг давхардсан тоогоор 128 удаа /нийт санал, хүсэлтийн 35 хувь/;

2.Сум, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр: Багийн соёлын төв болон сургуулийн байрыг завсарлах, засмал зам тавих, хүүхдийн цэцэрлэгийн гадна тохижилт, спорт талбай байгуулах, эрчим хүчний сүлжээнд холбогдоход дэмжлэг үзүүлэх, соёлын өв, дурсгалд газрыг хамгаалах, орон нутагт үлдэх бүтээн байгуулалт хийх, орон нутагт тулгарсан асуудалд тусалж үзүүлэх зэрэг санал, хүсэлт давхардсан тоогоор 54 удаа /нийт санал, хүсэлтийн 17 хувь/;

3.Төслийн нөлөөлөлд өртсөн болон өртөж болзошгүй нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр: Орон нутгаас ажилтан авч ажиллуулах, гүний худаг гаргаж өгөх, сургуулийн хүүхдийн хичээлийн хэрэгсэл авахад дэмжлэг үзүүлэх, орон нутгаас их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг төлөх, мал багатай иргэдийг малжуулах, уурхайн ажилчдын хэрэгцээнд мах, сүү, цагаан идээ авч байх, орон нутгаас ажиллаж байгаа иргэдийг тогтвор суурьшилтай ажиллуулах, олборлосон нүүрс болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс нутгийн иргэдэд хөнгөлөлттэй үнээр борлуулах, иргэдийн нөхөрлөл, бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллах зэрэг давхардсан тоогоор 152 удаа /нийт санал, хүсэлтийн 38 хувь/;

4.Баг, хорооны нийтийн хурлын үеэр гарсан бусад санал, хүсэлт: Уул уурхайн төсөл хэрэгжүүлэхийг дэмжсэн болон татгалзсан, Багийн Иргэдийн Нийтийн Хурал, Багийн Засаг даргатай нягт хамтарч ажиллах, жилийн эцэст үйл ажиллагаагаа тогтмол тайлагнадаг байх, уурхайн эдэлбэр газрыг хаших, мал орж унахаас хамгаалах, тээвэрлэлт хийх зам дагуу малын гарц, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, уул уурхайтай ойр гүний худгуудад тогтмол шинжилгээ, хэмжилт хийх, нутгийн иргэдийн санал бодлыг авч байх зэрэг санал, хүсэлт давхардсан тоогоор 48 удаа /нийт санал, хүсэлтийн 10 хувь/.

3.2. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.

БОНБУтХ-ийн 6 дүгээр зүйл “Аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл,

орчны онцлогийг тодорхойлж, хянуулахад төлөв байдлын нөлөөллийн үнэлгээний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

Мөн тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилга арга хэмжээ тогтоож, хянуулахад хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ; Түүнчлэн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажилд шаардагдах зардлыг нөлөөллийн цар хүрээг харгалзан төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулах, эрх бүхий мэргэжлийн Эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулах явдал хэр бодитой хэрэгжиж байна вэ?

Аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож, цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр тодорхойлдог.


Олон улсын жишгээр төсөл хэрэгжүүлэгч хэрэгжүүлэх төслийнхөө ТЭЗҮ, зураг төсөл гэх мэт баримт бичгүүдийг боловсруулахдаа байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийлгэдэг бөгөөд үүнийг үндэслэн баримт бичгүүдээ боловсруулдаг.

Гэвч одоогоор уг үнэлгээг баримт бичиг боловсруулах явцад хийж байгаа нь цаг хугацааны хувьд хоцорч хийгдэх, төсөл хэрэгжүүлэгчдэд ач холбогдол багатай баримт бичиг болох, түүнчлэн тус тайлан нь чанар муутай, бүс нутгийн байгаль орчны ерөнхий мэдээллийг хуулсан баримт бичиг болж хувирсныг салбарын мэргэжилтнүүд шүүмжлэлтэй хандаж байна. Манай улсад батлагдсан техник эдийн засгийн үндэслэлтэй байж, дараа нь үнэлгээ хийх зохицуулалт үйлчилж байгаа нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажлын дараалал алдагдах, үр дүн, ач холбогдлыг бууруулах нөхцөлийг бий болгодог байна.

БОНБУтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.6 дэх хэсэгт заасан “Эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулах” зохицуулалтын “мэргэжлийн зөвлөлд хүргүүлж, хянуулна” гэснийг “шүүмж хийлгэж, дүгнэлт гаргуулах” байдлаар өөрчлөх нь хууль зүйн үр дагаврыг нэмэгдүүлэх, үнэлгээний тайлангийн чанар, хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэх боломжтой байж болзошгүй байна.

Хүснэгт 3. Канад улсын Бритиш Колумб муж уул уурхай ба байгаль орчны нөлөөллийн үнэлгээний систем, 2018

Environmental Assessment Process



Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоодог бөгөөд БОНБҮТХ хэрэгжиж эхэлснээс хойш өнөөг хүртэл нийт 4 удаа хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийсэн байна. Үүнд:

1. Заамарын алтны уурхайн бүс нутагт хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (2014)
2. Дорноговь аймгийн нутагт цацраг идэвхит ашигт малтмалын хайгуул, газрын тос, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа төмөр зам, авто замаас үзүүлэх хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (2015)
3. Багануурын нүүрсний уурхайн бүс нутагт хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (2019)
4. Тавантолгойн нүүрсний уурхайн бүс нутагт хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (2021) тус тус хийжээ.
5. Эдгээр хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс Заамар, Багануур, Тавантолгойн нүүрсний уурхайн бүс нутгийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хүлээн авч Байгаль орчны мэдээллийн сангийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулсан байна.

БОНБҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажилд шаардагдах зардлыг нөлөөллийн цар хүрээг харгалзан төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулах” зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн 712.5 сая төгрөгийн санхүүжилтээр Тавантолгой ба Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн байна.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажилд шаардагдах зардлыг олон улсын байгууллагын санхүүжилтээр хийсэн нь төсөл хэрэгжүүлэгч үнэлгээний ажилд шаардагдах зардлыг гаргах гэсэн зохицуулалт бодит байдалд хэрэгжихгүй байгааг харуулж байна. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний цар хүрээ өргөн, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид эдийн засгийн хувьд ач холбогдолгүй, тухайн үнэлгээг зайлшгүй хийх эрх зүйн хэрэгцээ шаардлага сул зэргээс шалтгаалан хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийгдэхгүй байх нөхцөл бүрдсэн гэж үзэж болохоор байна.

Иймд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зохицуулалтын хэрэгжүүлснээр уг харилцаанд оролцогч этгээдүүдэд хууль зүй, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, үр дагавар байхгүй, хуулийг хэрэгжүүлэхгүй байхад тооцох хариуцлага, хөшүүрэг мөн байхгүй байгаа нь оновчгүй зохицуулалт, механизм хуульчлагдаж байгааг харуулж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2.

БОНБҮТХ-ийн 7 дугаар зүйл. Иргэн аж ахуй нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтооход нөлөөллийн үнэлгээний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ? БОНБҮТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар “нөлөөллийн үнэлгээ нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”-нээс бүрддэг ба байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг “байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө” байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл орон нутгийн байгаль орчны алба хийдэг.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үнэлгээний шинжээч ерөнхий үнэлгээг ажлын 14 хоногт багтааж хуульд зааснаар “төслийг хэрэгжүүлэхээс татгалзах”, эсхүл “буцаах, хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх”, “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай” гэж үзсэн дүгнэлтийг аль нэгийг гаргадаг. Аймаг, нийслэлийн буюу орон нутгийн захиргааны байгууллагуудын дэргэдэх байгаль орчин, аялал жуулчлалын газар болон яамны шинжээчид байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгүйгээр тодорхой нөхцөл болзолтойгоор ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргадаг зохицуулалттай.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагуудад үнэлгээний 28 шинжээч буюу төрийн албан хаагч байгаль орчны ерөнхий үнэлгээг хийж байна. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 6 шинжээч жилд дунджаар 800 орчим ерөнхий

үнэлгээний дүгнэлт, нийслэлийн Байгаль орчны газрын 1 шинжээч жилд дунджаар 800-1100 дүгнэлтийг гаргаж байгаа нь нэгдүгээрт, хуваарилалт оновчгүй, хоёрдугаарт, уг үнэлгээний, цаашлаад байгаль орчны нарийвчилсан үнэлгээний чанарт нөлөөлж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт бодитой байх нөхцөл бүрэн бүрдэхгүй байж болох нөхцөл байдал үүссэн байна.

Ерөнхий үнэлгээний зохицуулалтыг төслийн ангилал, төрлөөс хамаарч олон улсын жишигт нийцүүлэн, мөн бусад салбарын хууль тогтоомжтой уялдуулан оновчтой байдлаар сайжруулах, хүний нөөцийн чадавх болон бодит байдалд нийцүүлэн уян хатан байдлаар өөрчлөх нь цаашдын ерөнхий үнэлгээний тайлангийн чанар, улмаар байгаль орчныг хамгаалах хариуцлагыг дээшлүүлэхэд ач холбогдолтой.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3.

БОНБУтХуулийн 8, 10 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

БОНБУтХ-ийн 8 дугаар зүйлд “нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”, мөн 10 дугаар зүйлд “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэсэн эсэх, тайлан, дүгнэлт үндэслэлтэй, зөв эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах ажиллагаа буюу үнэлгээний шинжилгээ”-ний талаарх зохицуулалтыг тусгажээ.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулсан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тулгуурлаж, тодорхой хугацаанд, төсөл хэрэгжүүлэгчийн захиалга, түүний төлбөрийн үндсэн дээр эрх бүхий мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэдэг бөгөөд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулахаас өмнө тухайн төслийн нөлөөлөлд өртөх иргэд буюу багийн иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлж, тэмдэглэл санал авдаг үйл явцын хүрээнд хэрэгждэг байна

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний талаарх зарим нэг тоон баримтыг судалж үзвэл:

✓ Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 1995-2019 оны хооронд нийт 3255 төсөлд хийсэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан батлагджээ. Үүнээс Хан-Уул дүүрэгт 1380 тайлан буюу 43%, Налайх дүүрэгт 469 тайлан буюу 15%, Сонгинохайрхан дүүрэгт 467 тайлан буюу 14%-ийг тус тус эзэлсэн байна;

✓ 2015-2019 оны хооронд нийслэл Улаанбаатар хотод хэрэгжсэн төслийн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр авч үзэхэд 405 төслийн БОННУ-ний тайлан батлагдсан буюу нийт төслийн 36 хувийг аялал жуулчлалын салбарын төсөл байгаа олонх хувийг эзэлж байна;

✓ 2019 онд нийт 10 удаа Мэргэжлийн зөвлөлийн хурал хуралдаж, 155 төслийн тайланг хэлэлцсэн байна. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн тайланг үйл 20 ажиллагааны чиглэл тус бүрээр нь авч үзэхэд уул уурхайн салбарын 125 тайлан хэлэлцэгдсэнээс Алтны шороон ордыг ашиглах төсөл 54 тайлан буюу 35%-ийг эзэлж байна;

✓ Мөн 2019 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн дэд зөвлөл 11 удаа хуралдаж, нийт 590 тайлан хэлэлцсэн байна. Үүнээс 50 нь нэмэлт тодотголын тайлан байна. Мэргэжлийн дэд зөвлөлийн нийт хэлэлцсэн тайлангийн 408

буюу 69% нь Улаанбаатар хотод хэрэгжих, хэрэгжиж буй төсөл байсан бөгөөд 182 тайлан буюу 31% нь орон нутагт хэрэгжиж буй төсөл байна. Эдгээр 590 тайлангаас дэмжигдсэн 535, хойшлуулсан 10, төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн төлөөлөл хүрэлцэн ирээгүй, тайланг аргачлалын дагуу гүйцэтгээгүй болон бусад шалтгаанаар 10 тайланг хэлэлцэлгүй буцаасан байна;

✓ Байгаль орчин үнэлгээ аудитын хэлтсийн 6 үнэлгээний мэргэжилтний 2019 онд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд шинжилгээ хийж, шүүмж өгч шинжээчээр ажилласан байдлыг авч үзвэл нэг мэргэжилтэн дунджаар 150 орчим төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан дээр ажилласан байна;

✓ 2019 он ойролцоогоор ажлын 250 хоногтой байсан бөгөөд 1 мэргэжилтэнд дунджаар Ерөнхий үнэлгээний дүгнэлт 140, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний 150 тайланд шүүмж хийсэн. Ажлын өдрөөр тооцож үзвэл 3 хоногт 1-2 ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн 3 хоногт 1-2 байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийж байна. 1 мэргэжилтэн 3 хоногт 3-4 Ерөнхий үнэлгээ болон БОНБНУ-ний тайлантай танилцаж шүүмж хийж байгаа нь ажлын хэт ачаалалтай ажиллаж байгаа нь харагдаж байна;

✓ Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2015-2021 оны хооронд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ”-тэй холбоотой нийт 607 хэрэг маргаан шийдвэрлэгдсэн байна. Эдгээр нэхэмжлэлийн агуулгын хувьд дараах агуулгуудад хуваагдаж байна:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгээгүйгээр үйл ажиллагаа явуулж байгааг шалгаж холбогдох арга хэмжээ авахгүй байгаа БОАЖЯ-ны эс үйлдэхүй нь хууль бус болох тухай;

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь хууль бус болохыг тогтоолгох;

- Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтэд холбогдох саналыг гаргахгүй байгаа тухай;

- Мэргэжлийн зөвлөл нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дагуу үйл ажиллагаагаа явуулж буй этгээдийг хууль бус үйл ажиллагааг зогсоосон актыг хүчин төгөлдөр буст тооцуулах тухай;

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгээгүй үйл ажиллагаа явуулсаар байсан зөрчлийг илрүүлж акт үйлдсэнийг хүчин төгөлдөр буст;

- Үйл ажиллагааны нөхцөлийг байгаль орны нөлөөллийн үнэлгээндээ тусгаагүй байхад дараагийн шатны байгууллага шийдвэр гаргасан нь хууль бус;

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4.8-д нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн Иргэдийн Нийтийн хурлын санал, тэмдэглэл гэж заасныг хэрэгжүүлэхэд олон талын хүндрэл тулгарч байна. Багийн Иргэдийн Нийтийн хурал нь жилдээ 1-ээс 2 удаа хуралдах тохиолдол их байгаа тул төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний мэргэжлийн байгууллага хурал хүлээж цаг хугацаа, эдийн засгийн хувьд алдагдалд орж хөрөнгө оруулалтаа алдах зэрэг бэрхшээл гарч байна. Мөн авто болон төмөр зам, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төсөл зэрэг олон аймаг, сум, багийн нутаг дэвсгэрийг хамарч хэрэгждэг төслийн хувьд төслийн нөлөөлөлд өртөх баг бүрээс санал авах боломжгүй байна. Мөн энэ заалтад нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл гэж заасан нь 2 нэгжээс санал тэмдэглэл авах хоёрдмол утгыг илэрхийлдэг байна.

Төслийн хүчин чадал, хамрах хүрээ, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл зэргийг үл харгалзах бүх төрлийн нарийвчилсан үнэлгээний тайланг Үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр зохицуулсан нь эдийн засгийн болоод цаг хугацааны хувьд төсөл хэрэгжүүлэгч нарт хүндрэл учруулж байна.

БОНБУтХ-ийн 10 дугаар зүйлийн дагуу үнэлгээний шинжилгээтэй холбоотой зохицуулалтыг холбогдох оролцогч талууд хэрэгжүүлж, практикт хэвшүүлсэн боловч үнэлгээний тайлангийн чанар сул, захиалагч, хяналт тавьдаг байгууллага, мөн хэрэгжүүлэгч байгууллагын буюу оролцогч талуудын шаардлагад бүрэн нийцдэггүй талаарх гомдол, санал, шүүмж, зөвлөмж уг хуулийг хэрэгжүүлэх хугацаанд байнга гарсаар иржээ. БОНБУтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.3-т “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгийн үнэн зөвийг хариуцах” талаар эрх бүхий мэргэжлийн байгууллагын үүрэгт тусгагдсан хэдий ч мөн зүйлийн хэрэгжилт мөн хангалтгүй байна.

Байгаль орчныг хамгаалах, тэнцэл алдагдахаас хамгаалах Үндсэн хуулийн зарчмын гол хэрэгжилтийн нэг болох байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний чанарыг сайжруулах, боловсруулах, хянах, санал, дүгнэлт өгөх, улмаар хэрэгжилтийн явц нь нийгэм, олон нийт, оролцогч талуудын шүүмжлэлтэй тулгарсаар байгаа нь түүнд холбогдох зохицуулалт нь оновчгүй, холбогдох хууль, журамтай зөрчилдсөн, хийдэл, давхардалтай, хэрэгжүүлэхэд нэлээдгүй хүндрэл, бэрхшээлтэй байна гэж үзэж болохоор байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4.

БОНБУтХ-ийн 9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

БОНБУтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна” гэж заасан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” батлагдан хэрэгжиж байна.

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч, дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг баталдаг. Алт, зэс, нүүрсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн менежментийн төлөвлөгөөг хянасан байдлыг сүүлийн 3 жилээр байдлаар авч үзвэл 2018 онд 114, 2019 онд 215, 2020 онд 140 менежментийн төлөвлөгөөг тус тус хүлээн авч хянасан байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 5.

БОНБУТХ-ийн 17 дугаар зүйл. Банк, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын байгууллагын үүрэгт холбогдох зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

Банк, санхүүгийн байгууллагууд нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй аливаа төслүүдэд санхүүжилт олгохгүй байх үүргээ сайтар биелүүлж байгаа ч тулгарч буй дараах хүндрэл, бэрхшээл тулгардаг байна. Тухайлбал:

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталгаажуулсан БОНБУ нь чанарын шаардлага хангадаггүй; БОНБУ хийж буй мэргэжлийн байгууллагууд, мэргэжилтнүүдийн чадавх сул;

2. Банк, санхүүгийн байгууллагууд өөрийн бүтцэд байгаль орчин, нийгэм, засаглалын асуудал хариуцсан нэгж, ажилтан ажиллуулж, өөрийн байгууллагаас батлан гаргасан байгаль орчны бодлого, дүрэм, журмын хүрээнд тухайн төсөлд эрсдэлийн үнэлгээ хийдэг бөгөөд шаардлагатай үед нь газар дээр нь очин ажиллаж, эрсдэлийг нарийвчилж тодорхойлдог;

3. Банк, санхүүгийн байгууллагууд нь үнэлгээний мэдээллийн сантай шууд холбогддоггүй учраас тухайн бичиг баримтыг олшруулах, үнэн зөвийг тогтоох, цаг хугацаа алдах зэрэг хүндрэлтэй, тулгардаг, өөрөөр хэлбэл, төр, хувийн хэвшлийн байгууллага хоорондын мэдээлэл дамжуулах харилцаа сул;

4. Банк, санхүүгийн байгууллагууд нь аливаа төсөлд санхүүжилт олгохдоо олон улсын банк, санхүүгийн байгууллага болон Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан заавар, зөвлөмж, удирдамжийг дагаж ажилладаг.

Өөрөөр хэлбэл, сүүлийн үед нийгэм, жөндөрийн үнэлгээ, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн үнэлгээ зэрэг шинэ тутам шалгуурууд нэмэгдсэн нь дотоодын үнэлгээний төрөл, ангилалтай нийцэхгүй байна.

5. Банк, санхүүгийн байгууллагууд нь БОНБУТХ-ийн 17 дугаар зүйлийг хэрэгжүүлэх өндөртэй эрмэлзэлтэй ажилладаг хэдий ч уг зүйл нь хэт ерөнхий, нарийвчилсан шалгуур, хэмжих үзүүлэлт, хүлээлгэх хариуцлага зэрэг механизмыг суулгаж өгөөгүй нь нэг талаар уг хуулийн ач холбогдлыг сулруулах, нөгөө талаар уг зүйлийн хэрэгжилт хангалттай түвшинд бус, харин ч банк, санхүүгийн байгууллагуудад тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Шигтгээ. УУХҮЯ, АМГ болон СЕСМИМ, Мериго төсөлтэй хамтран Ховд аймагт баруун бүсийн Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий, Увс, Завхан, мөн Дорнод аймагт зүүн бүсийн Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дундговь, Дорноговь, Төв аймгийн ЗДТГ, БОАЖГ, МХГ, сумдын удирдлага, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэж буй уул уурхай, байгаль орчны салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах сургалт, хэлэлцүүлгийн 2019 оны 06, 08 дугаар саруудад зохион байгуулав. Уг арга хэмжээнд Байгаль орчны үнэлгээ, аудит болон яамнаас 2019-2020 хэрэгжүүлэх арга хэмжээний талаар илтгэл тавьж, мэдээлэл өгч ажиллаа.

Мөн сургалт, хэлэлцүүлгийн хүрээнд “Уул уурхайн салбарын баруун, зүүн бүсийн Нээлттэй хаалганы өдөрлөг”-үүдийг зохион байгуулсан. Өдөрлөгт “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК, “Оюу толгой” ХХК, “МоЭнКо” ХХК, “Алтайн хүдэр” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Бор өндөр” ХК, “Цайрт минерал” ХХК, “Шинь шинь” ХХК, “Доншин газрын тос Монгол” ХХК, “Петрочайна дачин тамсаг Монгол” ХХК, “Алтан Дорнод Монгол” ХХК, “Монполимет” ХХК, “Монгол чех металл” ХХК, “Адуун чулуу” ХХК, “Степ гоулд” ХХК зэрэг ААН-ийн төлөөлөл оролцов.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж, байгаль орчны үнэлгээ, аудитын хэрэгжилтэд мониторинг хийсэн тайлангаас БОАЖЯ, 2019

Шигтгээ. Голомт банк нь 2015 онд Тогтвортой Санхүүжилтийн Бодлого батлан зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг зээлийн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ба 2019 онд зээлийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага болон байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах зарчмуудыг шинэчлэн “Зээлийн Бодлого”-доо тусгасан. Дараах төрлийн бизнесийн зээлийн хүсэлтүүдэд байгаль орчин, нийгмийн (БОН) эрсдэлийн үнэлгээг заавал хийж байна. Үүнд:

- Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн Зарчимд тусгасан анхаарах үйл ажиллагааны жагсаалтад багтсан бүх зээлийн хүсэлтүүд;
- Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн зарчимд тусгасан БОН-ийн өндөр эрсдэл бүхий салбарт хамрагдах бизнесийн зээлийн хүсэлтүүд /Өндөр эрсдэлтэй салбарт: уул уурхай, эрчим хүч, барилга, ойн аж ахуй, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, химийн бодис ашигладаг, худалдаалдаг, боловсруулдаг үйлдвэр зэрэг багтана/;
- Бусад 50 сая төгрөг буюу түүнтэй тэнцэх валютаас дээш дүнтэй, 12 сараас дээш хугацаатай бизнесийн зээлийн хүсэлтүүд. Голомт Банк нь шинэчилсэн БОН-ийн үнэлгээндээ Олон Улсын Санхүүгийн Корпорацийн (IFC) БОН-ийн эрсдэлийн удирдлагын стандарт болон зээлдэгчийн эдийн засгийн салбарт харгалзах Монгол Улсын хууль, дүрэм, стандарт, нормыг тусган баримт бичиг дээр суурилсан үнэлгээний аргачлалыг боловсруулсан бөгөөд анхан шатны, ерөнхий, нарийвчилсан гэсэн 3 үе шаттайгаар үнэлгээг хийж байна. Ингэхдээ зээлдэгчийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд хэрхэн нөлөөлөх байдлаар эрсдэлийн түвшинг БОН-д ээлтэйгээс эхлээд өндөр эрсдэлтэй хүртэлх 5 түвшинд ангилан банкны болон харилцагчийн БОН-ийн эрсдэлийг удирдаж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6.

БОНБҮТХ-ийн 19 болон 20 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь үр ашигтай, үр нөлөө бүхий байж чадаж байгаа эсэх, байгаль орчны хохирол нөхөн төлүүлэх механизмын суурь зохицуулалт оновчтой хуульчлагдсан эсэх? Зөрчлийн тухай хуулийн дагуу “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” буюу 500,000 төгрөгөөр торгох хариуцлага хүлээлгэдэг байна. Энэ нь хариуцлагагүй төсөл хэрэгжүүлэгчдэд эдийн засгийн хувьд хүндрэлгүй, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой менежментийн төлөвлөгөөний ач холбогдол буурах, улмаар тус харилцааг зохицуулсан БОНБҮТХ-ийн холбогдох зүйл, заалт хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж байн

Шигтгээ. “Б” ХХК-ийн эзэмшлийн XV-018415, XV-020376 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн 2018 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахгүй байгаа Өндөрхангай сумын Засаг даргын татгалзал болон эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоон, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахыг Өндөрхангай сумын Засаг даргад даалгуулах тухай нэхэмжлэлийн шаардлага бүхий захиргааны хэргийг хянан хэлэлцэв. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3.4, 106.3.13, 107 дугаар зүйлийн 107.5 дахь хэсгүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.3 дахь хэсгүүдэд заасныг баримтлан хариуцагч Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргын “Б” ХХК-ийн XV-018415, XV-020376 тоот тусгай зөвшөөрлүүдийн 2018 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоон, нэхэмжлэгч “Б” ХХК-ийн XV-020376 тоот тусгай зөвшөөрлийн 2018 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахыг хариуцагч Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргад даалгаж, нэхэмжлэлийн үлдэх хэсэг болох “Б” ХХК-ийн XV018415 тоот тусгай зөвшөөрлийн 2018 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөг батлахыг хариуцагчид даалгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.

Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээс, 2018

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас (хуучин нэрээр) 2017-2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 547 объектод байгаль орчны хяналт шалгалтыг хийж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийг шалгахад 502 аж ахуйн нэгж буюу 91.6% нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж ажилласан боловч 2013-2020 онуудад хяналт шалгалтаар 2,487 орчим зөрчил дутагдал илрүүлж, тухай бүрд нь хугацаатай албан шаардлага, зөвлөмж, актын биелэлтээр зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахдаа аж ахуйн нэгж бүрд адил загвар шалгуураар ханддаггүй, төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх хугацааг тодорхой зааж өгдөггүй, “жилдээ” гэсэн хугацаа тавьдаг, мөн зарим төлөвлөгөөнд хүснэгт нь зөрүүтэй, зарим ажил нэг аж ахуйн нэгжид төлөвлөгдсөн ч нөгөө аж ахуйн нэгжид төлөвлөгдөөгүй байдлаар баталдаг зэргээс шалтгаалан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар явах үед хяналт тавих, биелэлтийг тооцоход хүндрэл үүсгэдэг байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн нөлөөллийн үнэлгээгээр тавигдсан шаардлага болон уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу байршуулдаг бөгөөд БОАЖЯ-ны (хуучин нэрээр) Төрийн сангийн тусгай дансанд 2006-2020 оны хооронд нийт 1,135 аж ахуйн нэгж, байгууллагуудаас 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 17.9 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Гэвч БОНБҮТХ-ийн 9.15-т заасан “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмуудын хэрэгжилт хангалтгүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1.1. Үнэлэлт, дүгнэлт

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийхэд оролцогч талуудын үүрэг, хариуцлага тодорхой бус байгаагаас шалтгаалан байгаль орчин доройтох, байгалийн тэнцвэрт байдал алдагдах, нутгийн оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх явдал гардаг учраас үнэлгээний үйл явцад олон нийтийн оролцоо, хяналтыг хангах асуудлыг шийдвэрлэх, үнэлгээний тайланд нутгийн иргэдийн саналыг авах, тусгах, олон нийтийн оролцоог хангах зэрэг хэрэгцээ шаардлагын дагуу тус хуулийг 2012 онд шинэчлэн найруулсан. Мөн тус хууль батлагдсанаар байгаль орчны үнэлгээтэй холбогдох үйл ажиллагааны хамрах хүрээ, зохицуулалт, хяналт сайжрах, түүнчлэн байгаль орчинд аливаа сөрөг нөлөөлөл учрах, байгаль орчин бохирдон доройтохоос урьдчилан сэргийлэн, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлэх нөхцөл бүрдэх зэрэг эерэг үр дагавар гарна гэж хууль тогтоогч үзсэн.

1992 оны Монгол Үндсэн хуулийн дараа Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засаг бүхий тогтолцоонд шилжсэнээс хойш эдийн засгийн бүхий л үйл ажиллагаанд нэвтэрсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд салбарын төрийн, төрийн бус байгууллагаас бусад байгууллага, иргэдийн ойлголт, мэдлэг сул, уг үнэлгээний тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан байгалийн баялгийн ашиглалтын үр ашгийг хангаж чадаж байгаа эсэхэд итгэх итгэл сул, зохицуулалт нь давхардал, хийдэл, зөрчилтэй байгаа нь ажиглагдсаныг дурдах нь зүйтэй.

Олон улсын түвшинд хөгжсөн, хөгжиж буй, буурай хөгжилтэй орнуудад ч байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаарх ойлголт сул, эрх зүйн зохицуулалт нь байнга сайжирч ирсэн нь судалгааны явцад ажиглагдсан болохыг мөн дурдъя.

Гэвч үнэлгээ нь хэлбэрийн төдий, Үндсэн хууль хийгээд холбогдох бусад хуулиудад тусгасан байгаль орчныг хамгаалах зорилтыг хангахад бодит дэмжлэг үзүүлж, хуулийн зорилтыг хангах бус, хэрэгжилт оновчтой бус, түвшинд хангалтгүй байна.

БОНБУтХ-д процедурын шинжтэй хууль байх нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа нь уг хуулийг “тунхагийн” шинжтэй хэрэгжилтийг бий болгожээ.

1.2. Зөвлөмж

Зөвлөмж 1. БОНБУтХ-ийн 5 дугаар зүйл.

2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Их Хурал нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан, тухайлбал, уг хуулийн 4.1.27-д заасан “тухайн бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны унаган төрх, тэнцвэрт байдал, түүнчлэн эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаа”-г “нөлөөллийн урьдчилсан үнэлгээ” гэх тодорхойлолт, түүний холбогдох зохицуулалттай нийцүүлж, эсвэл уг хуулийн холбогдох зүйл, заалт, хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах замаар стратегийн үнэлгээ, түүний ач холбогдол, зохицуулалтыг БОНБУтХ-д илүү нарийвчлан тусгах нь зүйтэй. Түүнчлэн стратегийн

үнэлгээ хийх аргачлалыг холбогдох хуулийн шинэчлэл хийгдсэний дараа боловсруулж, мөрдүүлэх нь чухал ач холбогдолтойг тэмдэглэе.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дах хэсэг дэх “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд амьдрах...” зарчим, зохицуулалттай уялдуулж, стратегийн үнэлгээний нарийвчилсан зохицуулалтыг БОНБҮтХ-д илүү нарийвчлан тусгах нь зүйтэй байна.

Зөвлөмж 2. БОНБҮтХ-ийн 6 дугаар зүйл

Төлөв байдлын үнэлгээний зохицуулалт, үйл явцыг илүү нарийвчилж БОНБҮтХ-д тусгах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах төлөвлөлтийн үе шатанд тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоох, цаашид уг төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг зөв тодорхойлох, хянах, хувилбарын дүн шинжилгээг хийх зэрэг үйл явцыг илүү тодорхой, нарийвчилсан хууль зүйн зохицуулалтаар хангахаас гадна тус хуулийн шинэчлэлттэй уялдуулж холбогдох аргачлалыг сайжруулах нь зүйтэй байна.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зохицуулалт, үйл явцыг илүү нарийвчилж БОНБҮтХ-д тусгах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг оновчтой тодорхойлох, бууруулах, арилгах арга хэмжээ харилцан уялдаа, үр ашиг, үр дүнтэйгээр тогтоох, хөндлөнгийн шүүмж, шинжилгээ, хяналт болон мэргэжлийн зөвлөлийн хянах үйл явц зэргийг илүү тодорхой, нарийвчилсан хууль зүйн зохицуулалтаар хангахаас гадна тус хуулийн шинэчлэлттэй уялдуулж холбогдох аргачлалыг сайжруулах нь зүйтэй байна.

Зөвлөмж 3. БОНБҮтХ-ийн 7 дугаар зүйл

Нөлөөллийн үнэлгээний зохицуулалт, үйл явцыг илүү нарийвчилж БОНБҮтХ-д тусгах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, төслийн ангилал, төрлөөс хамаарч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас аливаа төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан оновчтой тодорхойлж, бууруулах, арилгах арга хэмжээ тогтоох буюу БОНБҮтХ-ийн 7.4-д тусгасан нөхцөлүүдийг илүү тодорхой, нарийвчилсан хууль зүйн зохицуулалтаар хангахаас гадна холбогдох аргачлалыг сайжруулах нь зүйтэй байна

Зөвлөмж 4. БОНБҮтХ-ийн 8, 10 дугаар зүйл

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зохицуулалт, үйл явцыг илүү нарийвчилж БОНБҮтХ-д тусгах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн ирээдүйн хөгжил болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалт тэдгээрт тавигдах байгаль, орчин, нийгмийн бодлого, гүйцэтгэлийн стандартын шаардлагатай уялдуулах замаар БОНБҮтХ-ийн 8.4-т заасан шаардлагууд, тэдгээрийн уялдаа холбоо, бусад үнэлгээ, техникийн бичиг баримтуудын уялдаа холбоо, хөгжлийн бусад шаардлагууд, тухайлбал, уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн

үнэлгээ зэргийг илүү тодорхой, нарийвчилсан хууль зүйн зохицуулалтаар хангахаас гадна тус хуулийн шинэчлэлттэй уялдуулж холбогдох аргачлалыг сайжруулах нь зүйтэй байна.

Мөн Монгол Улсын Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Дугаар 319,А/160 тоот тушаалаар батлагдсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын” хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргахад ашиглах төслийн ангиллыг олон улсын жишиг, мөн олон улсын байгууллагуудын шаардлагыг харгалзан үзэх, уялдааг ханган тодорхойлж, БОНБҮТХ-д тусгах нь зүйтэй байна.

Зөвлөмж 5. БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйл.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зохицуулалтыг илүү оновчтой болгож, БОНБҮТХ-д тусгах нь зүйтэй байна. Тухайлбал, төслийн ангиллаас хамаарч, ангилал тус бүрд тавигдах шаардлагуудыг тодорхойлох буюу шаталсан зарчмыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж 6. БОНБҮТХ-ийн 14 дүгээр зүйл

Дан ганц ашигт малтмал олборлох төслүүдээс гадна түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, олборлох төслүүдэд цар хүрээнээс хамаарч нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эсэхийг тогтоох шаардлагатай. Түүнчлэн төслийн нөлөөллийн талаар холбогдох оролцогчдийг танилцах боломжоор хангах нь зүйтэй байна.

Зөвлөмж 7. БОНБҮТХ-ийн 17 дугаар зүйл.

Банк, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын байгууллагын үүрэгт холбогдох зохицуулалтыг илүү оновчтой болгож, БОНБҮТХуульд тусгах нь зүйтэй байна.

Зөвлөмж 8. БОНБҮТХ-ийн 19, 20 дугаар зүйл.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шаардах төслүүдийг илүү нарийвчлан тодорхойлж, холбогдох хууль тогтоомж зөрчин гаргасан үнэлгээчний эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг нарийвчилан зохицуулах нь зүйтэй.

Нэгтгэсэн зөвлөмж.

БОНБҮТХ-ийн 5 бүлэг бүхий 20 зүйл, 95 хэсэг бүхий хэсэгт хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж үзэхэд 11 зүйлийн холбогдох хэсэгт, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 3.1.3-т “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэснийг тус тус үндэслэн БОНБҮТХ-ийн холбогдох зүйл, хэсэгт нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, эрх зүйн акт

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль., 1992;
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль., 1995;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль., 2012;
- ✓ Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам", 2013;
- ✓ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам., 2013;
- ✓ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам., 2014;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам., 2014;
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам., 2019;
- ✓ Байгаль орчны аудит хийх эрх олгох журам, Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал., 2019;

Хоёр. Бодлогын баримт бичиг:

- ✓ "Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого., 2020;
- ✓ Шинэ сэргэлтийн бодлого., 2021;
- ✓ "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин., 2020;
- ✓ Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр., 2020;

Гурав. Судалгааны тайлан:

- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэх механизмын бүтээмжийн үнэлгээ., 2020;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ. Доктор. И.Бямбахүү. 2022;
- ✓ Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог сайжруулах нь., АМЕП төсөл, 2021;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчлэлтэд зориулсан төслийн ангиллыг боловсронгуй болгох судалгаа., БОАЖЯ, 2022;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль ба холбогдох бусад хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа., БОАЖЯ, 2022
- ✓ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл., ХЭҮК, 2018;
- ✓ Багийн иргэдийн Нийтийн хурлаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэлэлцүүлсэн байдалд үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний тайлан., БОАЖЯ, НҮБХХ, 2017;

Дөрөв. Цахим эх сурвалж

- ✓ www.legalinfo.mn

- ✓ <https://met.gov.mn/>
- ✓ <https://eic.mn/>
- ✓ <https://shuukh.mn/>
- ✓ <https://www.parliament.mn/>
- ✓ <https://amep.mn/>



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

**“БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.НИЙТЛЭГ ЗҮЙ.....	3
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ.....	3
ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ.....	4
3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	4
3.2.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	4
3.3.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	5
3.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	6
ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	6
4.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	6
4.2.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	8
4.3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ.....	8
4.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	8
ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	9
5.1.Дүгнэлт, зөвлөмж.....	9

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийн, түүний үр нөлөөг тооцож, хуулийн төслийг боловсронгуй болгоход энэхүү үнэлгээний ажлын зорилго оршино.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

Үүнд:

- 1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.Хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах, хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх;

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Практикт хэрэгжих боломж
4. Зардал
5. Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд нэмэлт, өөрчлөлтийн төслийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулах зорилтод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ.

“Практикт хэрэгжих боломж” нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь анхдагч биш учраас шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтооход туршилтын ажиллагааг явуулах шаардлагагүй бөгөөд цаг хугацааны хомс боломж байсан тул сонгож аваагүй болно. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалтад Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх, үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөж байгаа зохицуулалтыг сонгож авсан.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь зардал үүсгэхгүй гэж үзсэн бөгөөд тайланг Зардлын тооцооны тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт нь холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн зорилго нь Монгол Улсын иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглах үйл ажиллагааг зохицуулах үндсэн арга механизм нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоо бөгөөд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр дамжуулан байгаль орчныг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэхэд оршино. Энэ зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Тухайлбал:

- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний системд олон нийтийн оролцоог хангах, иргэний мэдээлэл авах эрхийг эдлүүлэх;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний төслийн ангилалыг хуулиар хатуу тогтоосныг улсын хөгжил, цаашдын чиг хандлага, салбаруудын онцлог, олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх;
- ✓ Нөлөөлөх байдлын үнэлгээний хяналтын тэнцвэргүй байдлыг сааруулах;

Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөс дээрх зорилтуудтай холбогдсон, эдгээр зорилтуудыг хангах зорилгоор тусгагдсан зүйл заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг тооцно. Үүнд:

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. (Хуулийн төсөл нь 7 зүйлтэй.)

№	Зорилгод хүрэх байдал/ дагалдах зорилтууд	Сонгосон зүйл заалт
1.	Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах;	Хуулийн төслийн 1.3, 3.1, 3.8, 2 дугаар зүйл
2.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний системд олон нийтийн оролцоог хангах, иргэний мэдээлэл авах эрхийг эдлүүлэх	Хуулийн төслийн 1.3, 1.8, 1.10, 3.10, 3.11 дүгээр зүйл
3.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний төслийн ангилалыг хуулиар хатуу тогтоосныг улсын хөгжил, цаашдын чиг хандлага, салбаруудын онцлог, олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх	Хуулийн төслийн 1.1, 1.4, 1.9, 3.2, 3.7, 3.11 дүгээр зүйл
4.	Нөлөөлөх байдлын үнэлгээний хяналтын тэнцвэргүй байдлыг сааруулах	Хуулийн төслийн 1.2, 1.4, 1.5, 1.6, 1.8, 3.3, 3.4, 3.9, 4 дүгээр зүйл

3.3.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэхийг шалгав.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл заалт
“7.8.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг
“14.1.4.иргэний хүсэлтийн дагуу тухайн төслийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах;	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.8, 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэг
“18.6.Засаг дарга энэ хуулийн 18.5-д заасан иргэний хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 15.6-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.	
18.7.Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.”	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг
5.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэж, Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө уг үнэлгээний тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.	

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. (Хуулийн төсөл 7 зүйлтэй)

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1, 3.1, 1.3, 1.8, 1.10, 3.6, 3.10 дугаар зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж		Практикт туршилт хийх, практикт тухайн төрлийн харилцаа, чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдээс ярилцлага авах, гарч болох хүндрэлийг судлах
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийг төслийг шалгах
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсэг Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэг	Хуулийн төслөөс иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэж буй эсэхийг шалгах
5.	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
6.	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт" гэж энэ хуулийн 7.9.3-д заасан зэрэглэл III хамаарах төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнөх төслийн байршлийн байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг хэмээн заасан байна.

Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах;

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “6.8. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хянах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.” хэмээн заасан бол 1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “14.1.5.хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс гарсан үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүний нэмэлт тодотгол болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангана.” хэмээн заасан нь төсөл хэрэгжүүлэгчийн хувьд оролцогч талуудын эрхийг хангах, иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хэрэгжүүрийн тулд нөлөөллийн үнэлгээг хийлгэх, нөлөөллийн үнэлгээнд дан ганц байгалиас гадна нийгэмд үзүүлэх нөлөөллийг багтаасан учир зорилгыг бүрэн хангаж байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний системд олон нийтийн оролцоог хангах, иргэний мэдээлэл авах эрхийг эдлүүлэх

Хуулийн төслийн 1.8 дахь хэсэгт төсөл хэрэгжүүлэгч нь “14.1.4.иргэний хүсэлтийн дагуу тухайн төслийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах” хэмээн заасан бөгөөд 1.10 дахь хэсэгт “18.6.Засаг дарга энэ хуулийн 18.5-д заасан иргэний хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 15.6-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.”, “18.7.Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.” гэснээс гадна тухайн төслийн талаар засаг захиргааны анхан шатны нэгжээс эхлэн иргэдэд мэдээлэл хүргэхээр заасан нь тус зорилтыг бүрэн хангаж байна.

Нөлөөлөх байдлын үнэлгээний хяналтын тэнцвэргүй байдлыг сааруулах

Төслийн ангилал, түүнтэй холбогдох үнэлгээний түвшиг тогтоож өгснөөр нэг талдаа төсөл хэрэгжүүлэгчид хүндрэл чирэгдэл багатайгаас гадна төслийн хамрах хүрээ, цар хүрээг улам тодорхой болгон өгсөн байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний төслийн ангилалыг хуулиар хатуу тогтоосныг улсын хөгжил, цаашдын чиг хандлага, салбаруудын онцлог, олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх

Хуулийн төсөлд нөлөөллийн үнэлгээний холбогдох албан тушаалтныг тодорхой болгож, чиг үүргийг илүү тодруулсан бөгөөд стратегийн үнэлгээг ямар шатанд хэн хийхийг маш тодорхой тусгасан байна.

Түүнчлэн үнэлгээний шинжээчийн шаардлага, томилгоо, чиг үүргийг тодорхой заасан нь уг зорилтыг хангаж байна.

4.2. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийн хүрээнд “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны мэргэжилтэн, судлаач, аймаг нийслэлийн байгаль орчны газар, төсөл хэрэгжүүлэгч, иргэд, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлд өртөг, үнэлгээ хийсэн мэргэжлийн газар” зэргийг хамарна.

Нэмэлт өөрчлөлтийн хүрээнд нөлөөллийн үнэлгээг хянах эрх бүхий этгээд, шаардлагатай төслүүд зэргийг нарийвчлан тодорхойлсон учир талуудад хүлээн зөвшөөрөгдөх байдлын хувьд холбогдох шаардлагыг хангасан байна.

4.3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд холбогдох байгууллагаас тусгайлан санал ирээгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан “Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага”, 30 дугаар зүйлд заасан “Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангасан эсэх” мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судалж үнэллээ.

Дээрх байдлаар хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байна.

4.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараахь асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ. Үүнд:

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн тодорхой зорилтуудыг дэвшүүлэн тэдгээр зорилтуудад хүрэх шууд утга бүхий заалтуудыг нэмэлтээр оруулсан тул зорилтдоо хүрсэн гэж үзсэн.
Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн 1 болон 3 дугаар зүйлд заасан тодорхойлсон нэр томъёо нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байна.

Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан зүйл тогтоогдоогүй.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан зүйл тогтоогдоогүй
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төсөлд Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зүйл тогтоогдоогүй.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Төрийн байгууллагын чиг үүргийг шилжүүлсэн зүйл төсөлд тогтоогдоогүй.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон тухай ямар нэгэн зүйл заалт тусгаагүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтын талаар тусгаагүй байна.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хуулийн төсөлд аливаа хүний эрхийг хязгаарласан зохицуулалт байхгүй байна.
Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд жендэрийн эрх тэгш байдал хөндөгдөөгүй.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгаадаагүй.
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаадаагүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Төсөлд ямарваа нэгэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар заалт ороогүй болно.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1. Дүгнэлт, зөвлөмж.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ. Энэхүү хуулийн төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү судалгааны дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулах шаардлагатай.

Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалаас дөрвөн төрлийн зорилгыг тодорхойлж, эдгээр зорилгод хуулийн төслийн зүйл заалт хэрхэн нийцэж байгаад

үнэлгээ хийсэн. Үнэлгээний дагуу хуулийн төслийн зорилго нь төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан гэж үзэж байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахыг зорьсон бөгөөд уг зорилгын хүрээнд хуулийн төслийн 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.8, 1.9, 1.10, 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.7, 3.8, 3.10, 3.11, 2, 4 дүгээр зүйлд тус тус зохицуулж өгсөн нь хуулийн төслийн зорилгод нийцсэн, зорилгодоо хүрэх байдал нь эерэг байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангасан эсэх, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судалсан.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд дан ганц байгальд үзүүлэх нөлөөллөөс гадна нийгэмд үзүүлэх нөлөөлөл, түүний талаар оролцогч талуудын мэдэх эрх, оролцооны түвшинг бодитойгоор хангах, төслийн ангиллаас хамааруулан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний түвшин өөр өөр байхыг тусгаж өгсөн нь оролцогч талуудад хүртээмжтэй, тэгш, хүндрэл багатайгаар шийдвэрлэсэн хэлбэр хэмээн үзэж байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэлэхэд эерэг байна.

--- оОо ---



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

Нэг. Ерөнхий үндэслэл.....	3
Хоёр. Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардал.....	4
Гурав. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардал.....	5
Дөрөв. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад үүсэх зардал.....	6
Тав. Дүгнэлт.....	8

Нэг. Ерөнхий үндэслэл

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасан байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамрагдах хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг дээр дурдсанчлан “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 12.1.4-т заасан буюу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэнэ/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагуудад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, зардлыг бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно. Мөн зардал үүсгэгч этгээд болох хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад тодорхой үүрэг бий болгосон, түүнийг хэрэгжүүлэхэд мөнгөн зардал шинээр бий болохоор тусгагдсан эсэхийг шалгана.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2 дугаар зүйлд “Тохиолдлын тоо нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Ингэхдээ статистикийн тоо мэдээг ашиглах бөгөөд энэ талаар статистик тоо мэдээ байхгүй бол баримжаалж тооцно.” гэж заасан болон 4.4.2 дугаар зүйлд “Зарцуулах хугацааг тодорхойлохдоо бусад төрийн байгууллагад адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авах бөгөөд тэдгээрийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээгээр баримжаалж тогтооно.” гэж тус тус заасныг үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, тухайн салбарын мэргэжилтний мэдээлэл, саналыг баримтлан баримжаалах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтооно.

Хоёр. Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардал.

Энэ хэсэгт тухайн хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- ✓ Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- ✓ Хуулийн этгээдийн зардлыг тооцох;

- ✓ Хуулийн этгээдийн зардлын тоон үзүүлэлтийг тооцох;
- ✓ Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- ✓ Хялбарчлах буюу зардлыг бууруулах боломжийг шалгах;
- ✓ Хуулийн этгээдийн нэмэлт зардлыг тооцох;

Хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж, уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцно.” гэж заасан.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд үүрэг болгосон буюу шууд зардал үүсгэх болон шууд бусаар зардал үүсгэж болзошгүй гэж үзэж болох агуулга бүхий дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалт
1.	Хуулийн төслийн 2.4	“4.4.Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”
2.	Хуулийн төслийн 1.4	7.11.Төслийн хүчин чадал, талбайн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд энэ хуулийн 7.10-т заасан хугацааг харгалзахгүйгээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.
3.	Хуулийн төслийн 3.3	7.3.Төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, эскиз зураг, бизнес төлөвлөгөө, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын үнэлгээ, эсхүл тодорхойлолт, тухайн хамгаалалтын захиргааны болон сум, дүүргийн Засаг даргын санал, холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.”
4.	Хуулийн төслийн 3.6	8.7.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчны мэдээллийн санд цахим хэлбэрээр хадгална.”

5.	Хуулийн төслийн 3.9	10.5.Байгаль орчны нөлөөлийн үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна."
----	---------------------	---

Хэдийгээр хуулийн төсөлд хуулийн этгээдэд (төсөл хэрэгжүүлэгчид) хүлээлгэсэн дээрх зохицуулалтууд тусгагдсан боловч эдгээр нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох эрх зүйн актын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Өөрөөр хэлбэл дээрх зохицуулалтууд нь зардал шинээр үүсгэх зохицуулалт биш хууль болон эрх бүхий субъектын тогтоол, шийдвэрээр баталсан эрх зүйн актын дагуу хэрэгжиж байгаа, практикт хэвшсэн зохицуулалт байна. Хуулийн төслийн аливаа зардлыг зөвхөн шинээр зохицуулсан, нэмэлт үүрэг хүлээлгэсэн, уг үүргээс хамааран нэмэлт болон шууд зардал гарах тохиолдолд, өргөжүүлсэн хүрээнд тооцох болно.

Төсөлд тусгагдсан хуулийн этгээдэд үүрэг болгосон заалтууд нь хэдийгээр одоогоор хуульд тусгагдаагүй хэдий ч хуулийн этгээдийн хүлээх үүргийн хүрээнд агуулгаараа багтсан байх тул хуулийн этгээдэд нэмэлт зардал гаргах зохицуулалт биш болно. Өөрөөр хэлбэл тухайн төсөл хэрэгжүүлэгч байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийлгэх, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх, менежментийн төлөвлөгөө боловсруулах, хаалтын төлөвлөгөө боловсруулах хугацаа, үүргийг улам тодруулж өгсөн бөгөөд энэ нь хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэхгүй.

Гурав. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардал.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараах дарааллыг баримтална. Үүнд:

- ✓ Иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлох;
- ✓ Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- ✓ Тоон үзүүлэлтийг тооцох;
- ✓ Нийт дүнг тоцож гаргах;
- ✓ Хялбарчлах буюу зардлыг бууруулах боломжийг шалгах;

Энэ үе шатанд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан иргэний гүйцэтгэх үүргийг болон түүний мэдээллийн агуулгыг нэг бүрчлэн тодорхойлж, иргэнд үүсэх зардлын цаг хугацааны ачааллаар тооцдог болохыг дурдъя.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн этгээд болон төрийн байгууллагад үүрэг болгосон зарчмуудыг тусгасан байх бөгөөд иргэнд үүрэг болгосон заалт байхгүй байна. Харин хуулийн төсөлд иргэний эрхийг хангах, иргэнд эрх олгосон дараах зохицуулалтууд байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалтууд
1.	Хуулийн төслийн 1.8.	"14.1.4.иргэний хүсэлтийн дагуу тухайн төслийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах;
2.	Хуулийн төслийн 1.10	"18.6.Засаг дарга энэ хуулийн 18.5-д заасан иргэний хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 15.6-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.
3.	Хуулийн төслийн 1.10	18.7.Иргэн тухайн төслийн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно."

Хүснэгтэд дурдсанчлан төсөлд тусгагдсан иргэнд эрх олгосон заалтууд нь шаардлагатай гэж үзвэл иргэнд холбогдох үнэлгээ, төслийн мэдээлэлтэй танилцах эрхийг олгосон учир нэмэлт зардал гарах зохицуулалт биш байна.

Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх цаг хугацааны ачаалал болон зардал үүсэх зохицуулалт байхгүй тул тусгайлан зардал тооцох хэрэгцээ шаардлагагүй байна.

Дөрөв. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад үүсэх зардал.

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- ✓ Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- ✓ Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- ✓ Гарах зардлыг урьдчилан тооцох;
- ✓ Зардлыг нэгтгэн тооцох;
- ✓ Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах;

Хуулийн төсөлд төрийн байгууллагад үүрэг болгосон буюу шууд зардал үүсгэх болон шууд бусаар зардал үүсгэж болзошгүй гэж үзэж болох агуулга бүхий дараах зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

№	Хуулийн төслийн зүйл заалтын дугаар	Зохицуулалт
1.	Хуулийн төслийн 1.3	6.8.Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үр дүн, нөлөөлөл бууруулах арга хэмжээг тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хянах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.
2.	Хуулийн төслийн 1.4	7.14.Сум, дүүргийн Засаг дарга нь төсөл хэрэгжүүлэгчээс энэ хуулийн 7.13-т заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 10 хоногт багтаан судалж, хариу хүргүүлнэ.
3.	Хуулийн төслийн 1.4	7.15.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 7.13-т зааснаас бусад бичиг баримт шаардахгүй.”
4.	Хуулийн төслийн 1.4	“7.8.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
5.	Хуулийн төслийн 1.10	“18.6.Засаг дарга энэ хуулийн 18.5-д заасан иргэний хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 15.6-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.
6.	Хуулийн төслийн 3.2	5.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэж, Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө уг үнэлгээний тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.
7.	Хуулийн төслийн 4.4	“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгох бөгөөд шинжээчийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах үүрэг бүхий ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх шаардлагыг хангасан байна.
8.	Хуулийн төслийн 3.4	7.7.Нөлөөллийн үнэлгээний журам, үнэлгээ хийх төслийн ангиллыг Засгийн газар батлах бөгөөд уг

		журам, ангилалд байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээний арга, хянан магадлагаа, олон нийтийн оролцоо, ерөнхий үнэлгээ хийх харьяалал, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол, нийгмийн нөлөөллийн болон эрүүл мэндийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг тусгана.”
9.	Хуулийн төслийн 3.9	“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан эсэх болон үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Төсөлд тусгагдсан заалтууд нь өмнө нь төрийн байгууллагад хуулиар ногдуулсан чиг үүргийг илүү тодорхой болгон хуульчилсан бөгөөд нэг газар төвлөрсөн байсан хэт ачааллыг шат шатанд нь ангилан сааруулсан учир уг нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдсанаараа төрийн байгууллагад нэмэлт үүрэг ногдуулж, зардал үүсгэхгүй зохицуулалтууд байна.

Өөрөөр хэлбэл төсөлд тусгагдсан заалтууд нь хуулийн зохицуулалтыг хуулийн төслийн үзэл баримтлалд заасантай уялдуулан боловсронгуй болгосон агуулгатай байна.

Хүний нөөцийн хувьд аймаг дүүргийн Засаг дарга, эдийн засгийн чөлөөт бүсийн хувьд тухайн чөлөөт бүсийн Захирагч, салбар тус бүрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон улмаар Засгийн газрын ажлын алба, бүтэц, бүрэлдэхүүн нь төсөлд тусгагдсан зохицуулалтыг хариуцсан нэгж, газар хэлтэс, албатай болно.

Өөрөөр хэлбэл дээр дурдсан ажлын алба, газар хэлтэс, нэгж албадын хариуцсан ажлын чиг үүрэгт төсөлд тусгагдсан төрийн байгууллагын үүргийг хамааран гүйцэтгэх үүрэг байгаа тул төсөл батлагдсанаар төрийн байгууллагад хүний нөөцийн нэмэлт хэрэгцээ шаардлага гарахгүй бөгөөд улмаар төрийн байгууллага, төсөвт нэмэлт зардал үүсэхгүй гэж тооцохоор байна.

Тав. Дүгнэлт

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал” болон түүнтэй уялдуулан боловсруулсан хуулийн төслийн шинэчилсэн зохицуулалтууд нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн зохицуулалтуудыг илүү боловсронгуй болгосон, нарийвчилсан агуулгатай байгаагаараа хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад зардал үүсэхээр шинэ буюу нэмэлт үүрэг ноогдуулаагүй байна.

Нөгөө талаас, үзэл баримтлалд дурдсанчлан хуулийн төслийн холбогдох зохицуулалтууд нь иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, байгаль орчинд үүсэх нөлөөллийг бууруулах, иргэдийг мэдээлэл авах эрхээр хангах, төсөл хэрэгжүүлэгчид үүсэх хүндрэлийг бууруулах, төрийн байгууллагын ачааллыг хуваарилах иргэн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус зардлыг бууруулан, цаашдаа эдийн засагт хэмнэлтийн үр нөлөө үзүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага, хуулийн этгээдэд шинээр хүний нөөцийн хэрэгцээ шаардлага гарахгүй, улмаар хүний нөөцтэй холбоотойгоор цалингийн зардал гарахгүй гэж үзлээ.

Хуулийн төсөлд тусгагдсан нэмэлт өөрчлөлтүүд нь ихэнхдээ тухайн зохицуулалтыг боловсронгуй болгосон, зарим нэмэлт үүрэг нь одоо мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын зардлын хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох үүрэг байх тул хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал нэмэхгүй, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд аливаа нэмэлт зардал гарахгүй гэж дүгнэж байна.

---o0o---